



ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

2018.03.14, ЛХАГВА ~ №053 (852)

~ СОЁЛТ ХҮНИЙ ӨГЛӨӨ СОНИН УНШИХААС ЭХЭЛДЭГ ~

ҮНЭ: 1000₮

Цахим хуудсаар дамжуулан гар утасны хулгайг бууруулна

Он гарснаас хойш хоёрхон сарын хугацаанд 474 гар утас хулгайд алдагдсан байна. > 4

Дэлхийд ердөө наймхан

Масс үйлдвэрлэл бус зөвхөн нэг хүнд зориулж, цор ганц хувилбарыг хийж байна. > 6



■ Том компаниуд 10 жилийн өмнөхөөс бага татвар төлдөг нь илчлэгдлээ

■ Шиньжян-Уйгурт аюулаас хамгаалах зардал эрс өсөв

ZGM DAILY

Budget ends February with USD 73.1 billion surplus

Budget deficit lowered by 82.5 percent year over year. > 7

ОНЦЛОХ

УЛС ТӨР

Р.Амаржаргал, Х.Тэмүүжин, Э.Бат-Үүл нар Үндэсний бодлогын хороонд нэр дэвшсэнгүй.

Төрийн үзүүлж буй 332 үйлчилгээний 87 хувийг дижитал хэлбэрт шилжүүлнэ.

Ардчилсан намын дотоод сонгуулийн сурталчилгаа өчигдрөөс эхэллээ.

Шинэ Үндсэн хуулийг батлуулахаар улс төрийн дөрвөн хүчин нэгджээ.

ЭДИЙН ЗАСАГ

Төлбөрийн тэнцэл

1.3 тэрбум ам.долларын ашигтай гарав.


МХБ давхар бүртгүүлэх анхны компанийн хүсэлтийг хүлээн авлаа.

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл хоёр их наяд төгрөгт хүрч, 14.2 хувиар өсчээ.

"ЛэндМН ББСБ" компанийн хоёрдогч зах зээлийн арилжаа өнөөдөр эхэлнэ.

ТОП 20 индекс 20774.30 нэгж болж, 0.09 хувиар буурав.

ТОР 20 индекс (хувиар)



НИЙГЭМ

Монгол Улсын ажилгүй иргэдийн тоо 9.5 мянгаар буурчээ.

Улсын хэмжээнд энэ оны эхний хоёр сард 709.6 мянган мал зүй бусаар хорогджээ.

Польш, Куба, Болгар зэрэг найман улсад суралцуулах тэтгэлэгт хөтөлбөр зарлагдлаа.

Улсын хэмжээнд гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 54 хувиар өсчээ.

ДЭЛХИЙ

БНХАУ төрийн байгууллагууддаа бүтцийн шинэчлэл өрнүүлэхээр төлөвлөж байна.

Японд сонгуулийн насны доод хязгаар 20 байсныг 18 болгож, багасгав.

АНУ-аас шалтгаалан газрын тосны үнэ буурах эрсдэл үүслээ.

Европын холбоо аюултай барааны жагсаалтад спиннерийг багтаав.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

2018.03.14



БАГАВТАР ҮҮЛТЭЙ

ЦАГ АГААРЫН ДЭЛГЭЭРӨНГҮЙ МЭДЭЭЛИЙГ
8 ДУГААР НҮҮРЭЭС УНШИНА УУ



Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

ИННОВАЦИГҮЙГЭЭР ИРЭЭДҮЙН ТУХАЙ ЯРИАД Ч ХЭРЭГГҮЙ



Улс орнуудын хөгжил дэвшлийг байгалийн баялаг нь биш, инноваци, технологийн гайхамшиг тодорхойлдог. Гэтэл бид баялгаа асар хямд зарчихаад, оронд нь өндөр үнээр инноваци шингэсэн бүтээгдэхүүн авч байна. ►12

С.Батсайхан / ЗГМӨ

НИЙТЛЭЛЧИЙН БУЛАН

Тэтгэврийн зээлийн ард хүчирхийлэл нуугдаж байна

Б.Энхжаргал
@enkhjrglZGM

2017 оны байдлаар Нийгмийн даатгалын сангаас нийт 381.8 мянган тэтгэвэр авагч арилжааны арван банкаар дамжуулан тэт-

гэврээ авч байна. Тэдний 52.2 хувь нь Хаан банк, 39.6 хувь нь Төрийн банк, үлдсэн 8.2 хувь нь бусад арилжааны банкаар дамжуулан тэтгэвэртэйгээ золгодог. Ахмадуудын 60 хувь буюу 230.8 мянган хүн 680.9 тэрбум төгрөгийн тэтгэвэр барьцаалсан

зээлийг 18 хувийн хүүтэй, 23 хүртэл сарын хугацаатай авсан байна.

Харин нийт тэтгэвэр авагчийн найман хувь нь богино хугацааны буюу зургаа хүртэлх сарын барьцаалсан зээл авсан судалгааг ХНХЯ-наас гаргалаа.

Үүнээс харахад өндөр настнуудын 70 орчим хувь нь тэтгэвэрээ барьцаалж, арилжааны банкны өндөр хүүтэй зээлээр амьдарч байна гэсэн үг.

►3

ЭДИЙН ЗАСАГ

Эдийн засагт тогтвортой байдал ноёлно

Б.Баярмаа
@bayarmaaZGM


Эдийн засаг сайжирч, ард иргэдийн нуруун дээрх ачаа хөнгөрөх таатай жилүүд айсуй. Энэ онд дэлхийн эдийн засаг өнгөрсөн оны өсөлтөө хадгалж, 3.7 хувьтай байх таамгийг Дэлхийн банкнаас гаргаад буй. Энэ дүр зураг ч манай улсын эдийн засагт ажиглагдана гэдгийг “Эдийн засгийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага” форумын үеэр эдийн засагчид онцоллоо.

Манай улсын эдийн засгийн өсөлт 2011 онд оргил цэгтээ хүрч, 17 хувийг давсан бол 2016 онд 1.4 хувь болж унасан. Харин өнгөрсөн онд дахин сэргэж, ойрын жилүүдэд гараагүй 5.1 хувийн өсөлтөөр энэ онтой золголоо. Улсын эдийн засгийг ийнхүү өөдрөгөөр төсөөлж буй нь улс орнуудын эдийн засаг нийтээрээ сайжирч буйтай холбоотой. Ялангуяа, хөрш БНХАУ, ОХУ болон гадаад худалдааны идэвхтэй түнш орнуудын дотоодын нийт бүтээгдэхүүн, худалдааны чадавх өсвөл манай улсад эерэг нөлөөтэй. БНХАУ-ын дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлт 2018-2020 онд зургаан хувь дотор байх төлөвтэй байгаа. Харин удаан хугацаанд хямарсан ОХУ-ын эдийн засаг өнгөрсөн онд хасахаас нэмэх утга руу шилжиж 1.8 хувиар тэлсэн билээ.

►11

ЗГМ: ИНФОГРАФИК

ОХУ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬД НЭР ДЭВШИГЧИД



АЛТ

1318.15
0.37%

ЗЭС

6913
0.7%

10-ЧИНГИС БОНД

98.775
0.001%

ГЭРЭГЭ БОНД

100.87
0.01%

ХУРАЛДАЙ БОНД

113.02
0.01%

АМ.ДОЛЛАР

2396.22

ЮАНЬ

378.43

РУБЛЬ

42.06

Улс төр

УЛСЫН ИХ ХУРАЛ

Хаврын чуулган Үндсэн хуулийн өөрчлөлтийг онцолно

*УИХ-ын дарга
намрын чуулганы
хаалтын үгэндээ
түшээдийн ёс зүйн
асуудлыг хөндсөн*

Б.Даваатогтох
@datoZGM

УИХ-ын хаврын чуулган эхлэхэд 20 хүрэхгүй хоногийн хугацаа үлдээд байна. Хаврын чуулганаар шийдэх ёстой олон чухал асуудал бий. Гэхдээ энэ удаагийн чуулганы гол сэдэв нь Үндсэн хуулийн өөрчлөлт болно. 1992 онд баталсан ардчилсан Үндсэн хуульд 2000 онд засвар оруулсан ч өнөөдрийг хүртэл дордуулсан долоон өөрчлөлт хэмээн нэрлэгдэж буй. Үүнээс хойш үе үеийн парламентад Үндсэн хуульд өөрчлөлт оруулах асуудал хөндөгдсөн ч бодитоор хэрэгжээгүй юм.

Харин сүүлийн жилүүдэд дээрх асуудал хүчтэй яригдаж, УИХ-д 65 суудалтай МАН Үндсэн хуульд өөрчлөлт оруулахаар эргэлт буцалтгүй



ЗГМӨ

шийдэв. Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд хэд хэдэн Ажлын хэсэг байгуулж, хоёр гурван ч удаа хэлэлцүүлэг зохион байгуулж, хуулийн төслийн хар зургийг боловсруулж, ирэх хаврын чуулганаар хэлэлцүүлэх бүрэн боломжтой болсныг Ажлын хэсгийн ахлагч, УИХ-ын гишүүн Д.Лүндээжанцан намрын чуулганы төгсгөлд

онцолсон. Тэрбээр “Үндсэн хуульд нийт зургаан асуудлын хүрээнд 30-аад нэмэлт, өөрчлөлт оруулах гэж байгаа. Энэ нь Үндсэн хуульд өөрчлөлт оруулах хэмжээ хязгаарт багтана. Үндсэн хуулийн суурь үзэл баримтлалд өөрчлөлт орохгүй. Ард түмнээс олгосон зөвшөөрлийн хүрээнд Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар хоорондын

харилцаа, эрх мэдлийн тэнцвэр, хяналтыг тодорхой болгох, шүүх эрх мэдлийн зарим асуудлыг тодотгох, нутгийн захиргааны асуудал, төрийн хяналт шалгалтын тогтолцоо, төрийн албаны тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр зургаан багц сэдвийн хүрээнд төслийг боловсруулсан” гэдгийг тодотгосон.

Тэгвэл ирэх хаврын улс төрийн нэг том маргаан нь Үндсэн хуулийн өөрчлөлтөөр өрнөх нь тодорхой боллоо. Үүнээс гадна энэ чуулганаар шийднэ, ядаж хэлэлцэж эхэлнэ хэмээн найдлага тавьж буй хэд хэдэн хуулийн төсөл бий. Тодруулбал, хаврын чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад багтсан Сонгуулийн тухай хуулийн төсөл, Улс

ЗГМ: ТОДРУУЛГА

Ц.Оюунбаатар: Улс төрийн эсрэг үйл ажиллагаа явуулбал намын гишүүнчлэлээс хасна

МАХН-аас Үндсэн хуулийн төсөл боловсруулж, ард түмний дунд нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлжээ. Энэхүү хуулийн төсөлд уул уурхайн баялаг ард түмний дундын өмч байна гэдэг зүйл заалт орсон бөгөөд үүний төлөө нам гэж талцахгүйгээр хамтдаа зүтгэх ёстой гэдгийг МАХН-ын дэд дарга Ц.Оюунбаатар онцлов.

Тэрбээр “Улс төрийн дөрвөн нам улс орноо эдийн засаг, улс төр, нийгмийн хямралаас гаргах, монголчууд намын харьяалал харгалзахгүйгээр эх орондоо элбэг хангалуун аз жаргалтай амьдрах гарц үүдийг нээх эрдэмтэн судлаачдын боловсруулсан шинэ Үндсэн хуулийг дэмжиж тунхаглана. Монголчууд эв нэгдэлтэй нэг зүгт харж хөгжлийн эрчимтэй бодлоготой явахгүй бол дэлхийн улс орон, түүний дотор хоёр хөршөөсөө хөгжлөөрөө хоцорч гадаад улсаас эдийн засгийн хараат байдалд орно. Энэ

Энэ үеэр МАХН-ын дэд дарга Ц.Оюунбаатараас дараах зүйлийг тодрууллаа.

-МАХН-ын шинэ дүрэм, мөрийн хөтөлбөрийг Улсын дээд шүүх бүртгэхээс татгалзсан. Ингэхдээ мөрийн хөтөлбөр нь Үндсэн хуультай харшилж байна гэсэн тайлбар өгсөн?

-Манай нам II Их чуулганаа ард түмний өмнө нээлттэй, ардчилсан байдлаар нийт гишүүдтэйгээ хамтарч хийсэн. МАХН-ын Их хурлын баталсан мөрийн хөтөлбөр, дүрмийн өөрчлөлтийн талаар Улсын дээд шүүхэд бүртгүүлэхээр өгсөн. Бүртгэлийн ажил явагдаж байгаа. Улсын дээд шүүх бүртгэх асуудлыг хэлэлцэхээс

биш эвлэлдэн нэгдсэн намын дотоод асуудал руу оролцох аюулгүй байдалд сөргөөр нөлөөлнө. Энэ гарцыг олж харж шинэ Үндсэн хуулийг боловсруулж улс төрийн намуудтай хамтарч ажиллаж байна” гэв.

-МАХН-аас өнгөрсөн онд аливаа сонгуулийн үеэр намынхаа эсрэг ажиллавал намаас хасна гэх дүрмийн өөрчлөлтийг Улсын дээд шүүхэд бүртгүүлэхээр хүргүүлж байсан. Энэ удаагийн дүрэмд энэ өөрчлөлтийг тусгасан уу?

-МАХН-ын дүрмийн өөрчлөлтөд Улс төрийн намын тухай хуулийн дагуу бусад намын дүрмийн адил зүйл тусгасан. Шинэ дүрэмд МАН, АН-ын дүрэмд заагдсан улс төрийн эсрэг үйл ажиллагаа явуулсан, дотоод дүрэм, журам зөрчсөн нөхцөлд хариуцлага тооцно. Түүний хамгийн том хариуцлага нь намын гишүүнчлэлээс хасна гэсэн заалт бий. Энэ дагуу дүрмээ шинэчлэн найруулан баталсан. [ЗГМ]

НАМУУД

Дотоод сонгуулийн сурталчилгаа эхэллээ

Ардчилсан намын Үндэсний ротацийн сонгууль явагдаж буй. Сонгуулийн сурталчилгаа өчигдрөөс арван хоногийн хугацаанд өрнөх бол санал хураалт энэ сарын 25-нд болно. Ротацийн сонгуулийг Үндэсний бодлогын хорооны нийт гишүүдийн 30 хувьд хийхээр болсон.

Тэгвэл өчигдөр нэр дэвшигчдэд

үнэмлэхийг нь гардууллаа. Энэ үеэр Ардчилсан намын дарга С.Эрдэнэ “Ардчилсан нам дотоод сонгуулиа явуулж байна. Бид дотоод асуудлаа нээлттэй, ил тод байдлаар шийдвэрлэдэг. Ардчилсан намын ямар ч гишүүн Үндэсний бодлогын хороонд орох боломжтой. Энд нэр хүндтэй хэн нэгэн ротацид орчихлоо, Эрдэнэ өөрийнхөө хүнийг оруулах гэж байна

гэх үлгэр домог ярихаа одоо зогсоогооч ээ гэж хэлмээр байна. Ардчилсан намын гишүүдийн олонхын санал авсан хүн Үндэсний бодлогын хороонд орно. Ардчилсан намын ротацийн сонгууль албан ёсоор эхэллээ. Та бүхний сурталчилгаа нээгдэж байна. Ямар нэгэн булхай битгий хийгээрэй. Шударга өрсөлдөөрэй” гэж мэдэгдсэн. [ЗГМ]

Бодлогын нам болж өөрчлөгдөх ёстойг сануулав

МАН-аас санаачилсан Улс төрийн намын хөгжил сэдэвт хэлэлцүүлэг Тусгаар тогтнолын ордонд боллоо. УИХ-ын дарга М.Энхболдын захирамжаар өнгөрсөн онд Улс төрийн намын тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулах Ажлын хэсгийг УИХ-ын гишүүн С.Бямбацогтоор ахлуулан байгуулсан юм.

Ажлын хэсэг Улс төрийн намын тухай хуулийн төслийг боловсруулж буй бөгөөд

эрдэмтэн судлаачдын саналыг ийнхүү сонсов. Тэд бодлогын нам болж өөрчлөгдөх ёстой гэдгийг тодотголоо. Ингэхдээ нүсэр бүтцээс ангижирч, цомхон чадварлаг болох ёстойг дуулгалаа.

Мөн улс төрийн намын санхүүжилтийг ил тод болгох асуудлыг ч хөндөв. Хувь хүн, хуулийн этгээдээс хандив авдаг байдлыг зогсоож, парламентад суудалтай эсэхээсээ үл шалтгаалж, төрөөс

санхүүжилт авдаг болох нь бизнесийн нөлөөллөөс ангид байх бололцоотой болно гэж үзэж байгаа талаар ажлын хэсгийн гишүүн, УИХ-ын гишүүн Т.Аюурсайхан хэллээ.

Одоогийн байдлаар Улс төрийн намын тухай хуулийн төсөл эцэслэгдээгүй ч массын намаас бодлогын нам болж өөрчлөгдөх ёстой гэсэн концепид суурилж байгааг УИХ-ын гишүүн С.Бямбацогт онцоллоо. [ЗГМ]

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2018.03.14-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: **Дозатор насос түүний сэлбэг нийлүүлэх**
Тендер шалгаруулалтын дугаар: **МС-62/2018**

“ДПС-4” ТӨХК нь эрх бүхий тендерт оролцогчдоос “дозатор насос түүний сэлбэг нийлүүлэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу.

Тендерт оролцогч нь тендер илгээхийн өмнө 50.000 /тавин мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 2 жилийн жил бүрийн борлуулалтын орлого нь санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна. 2016, 2017 он тус бүрээр
- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой эзэлийн хэмжээ:** Тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна.
- Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:** Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: 2016, 2017 тус бүрээр/нотлох баримтын хамт/ сүүлийн 2 жилийн дүн Тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй үнийн дүнтэй ижил төстэй гэрээт ажил гүйцэтгэсэн байна.

Тендерийн хамт тендерт санал болгосон үнийн дүнгийн 2%-тай тэнцэх дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ. Засгийн газрын бондоор ирүүлсэн тендерийн баталгааг хүлээн зөвшөөрнө.

Тендерийг 2018 оны 04 дугаар сарын 14 -ны өдрийн 10.00 цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2018 оны 04 дугаар сарын 14 -ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.

Монгол улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, Эрчим хүчний гудамж, “ДПС-4” ТӨХК-ийн Захиргааны байр, 3 дугаар давхар, 312, 313 тоот өрөө Худалдан авах ажиллагааны хэлтэс
Утас 7018-1309, 7000-1357, 7017-1357, Факс 7018-13097000-1357

“УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2018 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 10.00 цагт Сүхбаатар дүүргийн нутаг дэсвгэр, Зуун айл хэвлэлийн хүрээлэнгийн зүүн талд байрлах Барилгын дэвшилтэт технологийн төвийн 6 давхрын хурлын танхимд болно.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал
Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах,
Компанийн 2017 оны аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан тэнцэл, түүнд хийсэн ТУЗ-ийн Аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцэх
Компанийн ТУЗ-ийн 2018 оны зардлын төсвийг хэлэлцэн батлах
Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах;
Компанийн бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх талаар хэлэлцэн батлуулах
Өрийг хувьцаагаар солих талаар хэлэлцүүлэх
Бусад асуудал

Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдөр 2018.03.30-ны өдрөөр тасалбар болно. Хуралд биечлэн оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчид саналаа 2018.04.20-ны өдрөөс өмнө өөрийн харьяалагдах Брокер дилерын компанид болон Номин юнайтед цогцолборын байранд байрлах ТУЗ-ийн нарийн бичгийн даргад ирүүлсэн байна. Хувьцаа эзэмшигчид саналын хуудас, хурлын материал, шийдвэрийн төсөлтэй ТУЗ-ийн нарийн бичгийн даргатай холбогдон Мягмар, Лхагва, Баасан гаригуудад 09-12 цагт Номин юнайтед цогцолборын байранд ирж танилцана уу.

Хурал зохион байгуулах комисс
Утас: 99116100, 94991996

Нийтлэлчийн булан

Ахмадуудыг тэтгэврийн зээл авахаас аргагүй байдалд үр хүүхдүүд нь хүргэдэг

◀1

Гэхдээ энэ нь 2017 оны сүүлийн статистик гэдгийг тодотгох нь зөв. Мэдээж өнгөрсөн сард болсон сар шинийн баяраар тэтгэврээ барьцаалж зээл авсан ахмад настны тоо тоймгүй нэмэгдсэн нь ойлгомжтой. Үүнийг Баянзүрх дүүргийн зөвхөн Шархад дахь банкны салбарт л гэхэд “Тэтгэврийн зээл” гэсэн хавтсанд багтахгүй хахсан цэнхэр дэвтрүүд тавцан дээрээс нурах шахам овоолоостой байснаас харж болно.

Ахмадууд өндөр настны тэтгэврээ зориулалтын дагуу сар бүр амьжиргааныхаа эх үүсвэр болгон ашиглаж чаддаггүй ийм байдал хэдий хүртэл үргэлжлэх вэ.

Энэ талаар ХНХ-ын сайд С.Чинзоригоос тодруулахад “Тэтгэврийн зээл төрийн үйлчилгээ биш. Харин арилжааны банкуудын бүтээгдэхүүн. Ийм бүтээгдэхүүн бий болж, иргэд хэрэглэж байгаа нь сайн хэрэг. Гэхдээ нөгөөтэйгүүр тэтгэвр гэдэг арилжааны банкны барьцаанд тавигдах зүйл биш. Тухайн өндөр настны сар тутмын амьжиргааг залгуулах эх үүсвэр. Гэтэл Монголын зарим арилжааны банк тэтгэвр барьцаалсан зээлийн үйлчилгээ бий болгочихсон. Ахмадууд тэтгэврийн хэмжээ бага, амьдралд хүрэхгүй байна гэхээсээ илүүтэй үхтэл үр харам гэсэн философиор ханддаг. Хөгшчүүд тэтгэврээ зөвхөн өөртөө зарцуулбал амьдралд нь нэмэр болох л мөнгө. Гэтэл хүүхдийн сургалтын төлбөр, эрүүл мэндийн үйлчилгээнд тэтгэврээ барьцаалан их хэмжээний зээл авч өгчихөөд байгаа тул “тэтгэврийн зээл”-ийн дарамтыг ахмадууд үүрээд байгаа юм” гэлээ.

Үүнийг задлаад үзвэл, ахмадуудын дийлэнх нь өөрийнхөө хэрэгцээг хангахаас илүүтэй ихэвчлэн үр хүүхдийнхээ хэрэгцээ, шаардлага, гуйлгыг биелүүлэхээр зээл авдаг байна. Тэр ч бүү хэл зээл авахаас аргагүй байдалд ортол эцэг эхээ “дарамталж”, авсныг нь хуу хамдаг ачлалгүй үр хүүхдүүд ч байдгийг баримтаар хүргэе.



Төр хууль гаргаж, тэтгэвр барьцаалсан зээлийн үйлчилгээг хүчээр зогсоохоос эмээж байна.

С.Батсайхан / ЗГМӨ

Тэтгэврийн зээлийн ард хүчирхийлэл нуугдаж байна

МУИС-ийн дэргэдэх Профес- сорын багаас “Тэтгэврийн зээлийг хэн авч байна, юунд зарцуулах, ямар зорилготой авав” гэсэн судалгаа явууллаа. Гэтэл зориулалт нь “хэрэглээ” гэж гарчээ. Тэгэхдээ ахмад настны хэрэглээ бус ажил хийхгүй гэртээ суудаг залуусын хэрэглээ гэх дүн гарсан байна.

С. Чинзориг: Тэтгэврийн зээл төрийн үйлчилгээ биш

МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн багш Л.Оюун “Улаанбаатар хотын ахмадууд тэтгэврийн зээл аваад үр хүүх- ддээ өгчихдөг тул өөрсдөө улаан мөнгөгүй болчихдог. Мөнгөгүй хүмүүс яах вэ, мэдээж хотоор өдөржин дэмий тэнэдэг юм байна. Азаар автобус нь үнэгүй.

Хоол идэж, цай уусан ч юм байхгүй. Тэгээд орой үр хүүхдээ, нөгөө хүчирхийлдэг хүмүүсээ гэртээ ирэхээс нь өмнө очиж, унд хоолыг нь бэлтгэдэг байх жишээний амьдралын хэв маяг нийтлэг. Ийм жишээ олон гарсан. Энэ бол үнэхээр аюултай үзэгдэл” хэмээн өөрийнхөө багийн судалгааг танилцуулахдаа хэлсэн.

Эндээс харахад төрийн үйлчилгээг барьцаалсан арил- жааны банкны бүтээгдэхүүнийг хуулиар хориглоход буруудахгүй гэсэн дүгнэлтэд хүрч болохоор. Энэ асуултыг ХНХ-ын сайд С.Чинзоригт ч мөн тавилаа. Тэрбээр “Нэгэнт бий болсон зүйлийг одоо хориглож болохгүй байна. Яагаад гэвэл хэрэгцээ нь байна” гэсэн хариулт өгөв. Харин ахмадуудыг гар дээрээ тавих таван ч төгрөггүй болохоос сэргийлэх үүднээс тэтгэврээрээ зуун хувь төлдөг зээлийн нөхцөл дээр нэг ядмагхан өөрчлөлт оруулсан нь саяхнаас хэрэг- жиж эхэллээ. Энэ нь тэтгэвр барьцаалсан зээлийн 70 хувийг төлүүлж, үлдсэн 30 хувийг

тэтгэвр авагчийн гар дээр үлдээх ёстой юм. Ингэснээр тэтгэвр авагч энэ мөнгөөр амьдралаа залгуулахад нь нэмэртэй гэж Засгийн газар үзсэн.

Харин бусад орны хувьд тэтгэврийг тухайн сардаа л ашиглах ёстой гэсэн бодлого баримталдаг. Японд гэхэд тэтгэвр барьцаалсан зээл олгохыг хуулиар хориглодог. Мөн манай урд хөрш БНХАУ-д эцэг, эхээ үл хайхран, асрахгүй байгаа иргэдийг “хар жагсаалт”-д бүртгэж, цаашлаад банкны зээл олгохгүй, данс нээхгүй байх эрхийг орон нутгийн захир- гаанд өгдөг юм билээ. Анх 2013 онд БНХАУ-д энэ талаар хууль баталж, настай эцэг, эхээ тогтмол эргэж тойрдоггүй хүмүүсийг хариуцлагад татахаар журамласан нь нийгэмд сайн үр дүн авчирсан гэдэг.

Гэтэл Монгол Улсад настай эцэг эхээ асрах нь битгий хэл тэтгэврийнх нь хэдэн төгрөгийг орлогын эх үүсвэрээ болгодог хүмүүс захаас аваад дүүрэн байгаа нь даанч харамсалтай.

Хүү, охин эсвэл бэр, хүргэн нь шаналгаж, дарамталж, хүчээр тэтгэврийн зээл авахуулсаар байна.

● **Ахмадуудын 70 орчим хувь нь тэтгэврээ барьцаалж, арилжааны банкнаас хүүтэй зээл авч амьдардаг**

● **Настнууд ядуу, эдийн засгийн чадавхигүй, хүний хараат байдалтай амьдарч байгаа нь тэтгэврийн зээлтэй холбоотой.**

● **Японд тэтгэвр барьцаалсан зээл олгохыг хуулиар хориглодог бол манай урд хөрш БНХАУ-д эцэг, эхээ үл хайхран, асрахгүй байгаа иргэдийг “хар жагсаалт”-д бүртгэж, шийтгэдэг.**

Үүний уршгаар өндөр настнууд маань жинхэнэ ядууралд авгаж, эдийн засгийн чадавхигүй, хүний хараат байдалтай амьдарсаар энэ насыг элээх тавилантай эвлэрч явна. Салбарын сайдын хэлсэн үгнээс харахад төр хуулиар зохи- цуулж, тэтгэвр барьцаалсан зээлийн үйлчилгээг хүчээр зог- соохоос эмээж байна. Магадгүй ахмадууд биш юм аа гэхэд эцэг эхээ тэтгэврийн зээл авахуулахаас аргагүй байдалд хүргэдэг хүүх- дүүд ийм шийдвэр гаргагчдаас сонгуулийн үеэр хариугаа авна гэж болгоомжилдог байх. Зөвхөн энэ удаагийнх биш эрх барьж буй нам, түүнээс байгуулагдсан Засгийн газар олон нийтэд таалагдах шийдвэрийг эцсийн үр дүнг нь харалгүйгээр гаргасаар ирсэн. Гэхдээ ядаж тэтгэврийн хэдэн төгрөгийг ажилгүй залууст завшуулахгүй, банкны хүүнд мөлжүүлэхгүй байх боломжийг хэдэн ахмаддаа олгоод, тэтгэвр барьцаалсан зээлийн үйлчилгээ гэгчийг тас хориглосон хууль гаргаад өгөөч төр, засгийнхан минь ээ. [ЗГМ]

С.ЦОГТБАЯР ЗУРЖ БАЙНА



Нийгэм

2018 он гарснаас хойш хоёрхон сарын хугацаанд 474 гар утас хулгайд алдагдсан байна

Г.Оюунтөгс @oyuntugsZGM

Нийслэлийн Цагдаагийн газрын Мөрдөн шалгах газрын халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа Э.Бат-Эрдэнээс дараах зүйлийг тодрууллаа.

-Сүүлийн жилүүдэд халаасны хулгайн гэмт хэрэг, ялангуяа, гар утасны хулгай нэмэгдэх болсон. Он гарснаас хойш энэ төрлийн хэчнээн гэмт хэрэг



С.Батсайхан / ЗГМ©

Хулгайд алдагдсан нийт гар утасны 45 хувь нь Iphone 43 хувь нь samsung, үлдсэн 13 хувь нь бусад загварынх байжээ.

код, Samsung загварынхтай бол нууцлалын кодыг болон өөрийн нэр, утас гээд шаардлагатай мэдээллээ бүртгүүлнэ. Хэрэв утсаа алдсан тохиолдолд уг сайтад дахин нэвтэрч ямар загварын гар утсаа хэзээ алдсанаа тэмдэглэдэг болно. Ингээд гар утасны оператор компаниудын аль нэгнийх нь хэрэглэгч нэвтэрсэн тохиолдол тухайн эзэмшигчийн утсанд мэдээлэл очно. Үүрэн холбооны операторын ийм дугаартай хэрэглэгч, нэвтэрсэн гэх мэдээллийг авна гэсэн үг. Сайтын хөгжүүлэлт одоо явагдаж байгаа. Удахгүй хэрэглэнд нэвтрүүлнэ. -Энэ төрлийн гэмт хэрэгт ямар хариуцлага ногдуулдаг вэ? -Өмнө нь Захиргааны тухай хуулиар арга хэмжээ авдаг байсан. Уг хуулиар хулгай хийсэн гэмт хэрэгтэн 20 мянган төгрөг төлөөд л суллагдчихдаг байлаа. Прокурорын шатанд очихоор хохирлыг нөхөн төлүүлсэн,

Э.Бат-Эрдэнэ: Цахим хуудсаар дамжуулан гар утасны хулгайг бууруулна


бүртгэгдээд байна?

-Жилд 7500-8000 гар утас хулгайд алдагддаг. Үүнийг 365 хоногт хуваагаад үзвэл өдөрт дунджаар хоёр гар утас алдагддаг гэсэн үг. 2018 он гарснаас хойш хоёрхон сарын хугацаанд 474 гар утас хулгайд алдагдаад байна. Сүүлийн таван жилийн хугацаанд халаасны хулгай, гар утасны хулгайн гэмт хэрэг буурахгүй байна.

-Энэ төрлийн гэмт хэрэг нэмэгдэх болсон шалтгааныг тогтоосон уу?

-Хууль бус зах зээлд гар утасны эрэлт их байна. Энэ зах зээлийг гар утасны ченжүүд үүсгэдэг. Мөн барьцаалан зээлдүүлэх газар буюу ломбардууд эзэн нь тодорхойгүй гар утас авч байгаа нь өөгшүүлэх гол шалтгаан болж байна. Онцлоход, 116 гар утас хулгайлсан гурван ченж одоо шалгагдаж байна. Мөн Iphone загварын гар утасны IMEI код тайлах боломжтой программ суулгасан гар утасны засварчны зөөврийн компьютерийг хураан авч, шалгасан. Гэтэл

ЗГМ: ИНФОГРАФИК



тус программаар 1260 гар утас уншигдсан байсан.

-Ломбардуудад хяналт тавих боломжгүй юм уу?

-Өнөөдрийн байдлаар Улаанбаатарт 500 гаруй ломбард үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс 300 нь албан ёсны бүртгэлтэй.

Хулгайн гэмт хэргийн гаралтыг бууруулахын тулд өмнө нь цагдаа нар ломбарданд шалгалт хийж, хулгайн эд зүйл мөн эсэхэд хяналт тавьдаг байсан. Харин энэ оноос эхлэн барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ эрхлэгчид барьцаанд тавьж буй иргэний цахим үнэмлэхийг заавал хуулбарлан авч, бүртгэдэг болсон. Энэ

бүртгэлийг цаасан болон цахим хэлбэрээр хийнэ. Ингэснээр гар утасны хулгайн гэмт хэрэг багасах бүрэн боломжтой гэж үзэж байгаа. -Үүнээс өөр ямар дорвитой арга хэмжээ авч байгаа вэ? -www.smartdevice.mn гэсэн цахим хуудас ажиллуулна. Уг сайтад тухайн иргэн Iphone загварын утастай бол IMEI

эвлэрсэн гээд хэрэгсэхгүй болгочихно. Шүүхээр орохоор анх удаа хэрэг үйлдсэн гээд тэнсэн авчихдаг байсан. Тэгвэл Зөрчлийн тухай хуулиар хариуцлага тооцох хэлбэрийг чангаруулж, гэмт хэрэгтэн 5000 төгрөгийн хулгай хийсэн ч 7-30 хоног баривчилж, албадан сургалтад хамруулдаг болсон. [ЗГМ]

Боловсрол

Улсын тэтгэлэгт хөтөлбөр эхэллээ

Сургалтын төрийн сангийн зээлээр болон хамтарсан тэтгэлэгт хөтөлбөрүүд зарлагдлаа. Засгийн газар хоорондын тэтгэлгээр бакалаврын сургалтад суралцах сонгон шалгаруулалтад Монгол Улсын магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль, коллежийн I, II дамжааны 3.0 болон түүнээс дээш голч дүнтэй оюутнууд

бүртгүүлэх боломжтой. Харин магистр, докторын сонгон шалгаруулалтад бакалавр, магистрын зэрэгтэй, 3.0 ба түүнээс дээш голч дүнтэй иргэн хамрагдана. Сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэдийн нэрсийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас тэтгэлэг олгогч улсад

нэр дэвшүүлэх бол эцсийн шийдвэрийг хүлээн авагч тал гаргах аж.

Одоогийн байдлаар Румын, Латви, Беларус, Хорват, Армен, Иран, Камбож, БНАСАУ, Франц зэрэг улсад Монгол Улсаас оюутан сургах, оюутан солилцох хүсэлт тавьж, гэрээ байгуулах бэлтгэл ажил хийгдэж байна. [ЗГМ]

Үйлчилгээ

Орон нутагт 5000 ам.метр хүртэлх газар өмчлөх боломжтой

Монгол Улсын иргэн орон нутагт 5000 хүртэлх ам.метр газар өмчлөх боломжтой болжээ. Орон нутагт газар өмчлөх хүсэлтэй нийслэлийн иргэд Дүнжингарав, Мишээл, Драгон, Оргил төвд байрлах нийслэлийн Газрын албаны цонхноос “Улаанбаатар хотод газар өмчлөөгүй” гэсэн тодорхойлолт авч, тухай орон

нутгийн газрын асуудал эрхэлсэн байгууллагад хандах аж. Газар өмчлөхдөө иргэн тухайн газрыг эзэмших эрхийн гэрчилгээтэй, ямар нэгэн зөрчилгүй байх шаардлагатай.

Мөн суурьшлын бүсийн гадна байрладаг бол шинээр газар олгохгүй юм байна. Иргэн гэр бүлийн хэрэгцээний

зориулалтаар газрыг нэг удаа үнэгүй өмчилж авах эрхтэй гэж Газар өмчлүүлэх тухай хуульд заасан байдаг. Тэгвэл энэхүү хулийн хугацаа тавдугаар сарын 1-нд дуусах тул нийслэлийн Газрын албанаас иргэдэд газраа үнэгүй өмчлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэхээр нэг сарын хугацаатай аян санаачилжээ. [ЗГМ]

МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨРТ

“Марш тактик-2018” өрсөлдөөн дүүрэн боллоо

Монгол Улсад орчин цагийн зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 97 жилийн ой, монгол цэргийн баярыг угтаж Худалдаа хөгжлийн банкны Хамгаалалт, аюулгүй байдлын газар гуравдугаар сарын 10-ны өдөр Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн хээрийн полигонд “Марш тактик-2018” тэмцээнийг дөрөв дэх жилдээ амжилттай зохион байгууллаа.

Энэхүү тэмцээн ХХБ-ны хамгаалалт, аюулгүй байдлын түвшинг дээшлүүлэхийн зэрэгцээ гэмт халдлага болон бусад эрсдэлтэй, аюултай нөхцөл үүсэхэд түүнд няцаалт өгөхөд бэлэн байх гар нийлсэн хамтач ажиллагаа, хамгаалалтын ажилтнуудын эмх цэгцтэй багаар ажиллах чадвар, сахилга дэг журам, харилцааны соёл, гадаад үзэмж хамгаалалт, аюулгүй байдлын арга тактик, албаны ур чадварыг шинэ түвшинд гаргах зорилготой юм.

Энэ жилийн тэмцээнд тус банкны орон нутаг дахь салбар, тооцооны төвийн хамгаалалтын ажилтнуудын нэгдсэн баг анх



удаа оролцлоо.

Нийт 100 гаруй хамгаалалтын ажилтан найман багт хуваагдан өрсөлдөхөд Т.Үнэнзориг даргатай дөрөвдүгээр тасаг тэргүүн байр эзэлж, өргөмжлөл, цом, 500 мянган төгрөг, Б.Сайнбуян даргатай хоёрдугаар тасаг хоёрдугаар байр эзэлж, өргөмжлөл, 300 мянган төгрөг, хамгаалалтын ажилтан Б.Төвшин ахлагчтай Мөнгөн зөөврийн хамгаалалтын баг гуравдугаар байрыг эзэлж, өргөмжлөл, 200.000 төгрөгөөр шагнууллаа. Тэмцээний тусгай байрын шагналыг нууцын ажилтан Х.Эрдэнэбилэг ахлагчтай орон нутгийн салбар, тооцооны төвүүдийн нэгдсэн баг авлаа.

“Марш тактик-2018” тэмцээн нь хамгаалалтын ажилтнууд бие биенээсээ суралцаж туршлагажсан, албаны ур чадвараа ахиулсан, тэсвэр хатуужил суусан, нийт бүрэлдэхүүний бэлэн байдал, албаны ур чадварын түвшин, гар нийлсэн хамтач ажиллагааг дээшлүүлэн хамгаалалтын ажлын арга тактик, алдаа оноогоо дүгнэж цэгнэсэн томоохон сургалт боллоо.

[ЗГМ СОНИН]

“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээ бүрнээ сахин, олон ургаль үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилгоо болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбаатарын ДОЛГИОН

Ерөнхий эрхлэгч
Баатарын ДУЛАМХОРЛОО

Зөвлөх
Шатарбалын ДАВААДОРЖ

Орлогч эрхлэгч
Лхагважавын СУГАРМАА
Утас: 99903584

РЕДАКЦ

Улс төр, нийгэм, эрэн сурвалжлах мэдээллийн алба
Эдитор Б.Даваатогтох
Утас: 99901637

Эдийн засаг, уул уурхайн мэдээллийн алба
Эдитор Б.Баяртогтох
Утас: 99901532

Цахим контент, бүтээлч үйлдвэрлэлийн алба
Эдитор Г.Баярсайхан
Утас: 99903574

ЗАР СУРТАЛЧИЛГАА

Утас: 99903581
99903578
99909472
99907843

ХАЛГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
I хороо, Энхтайваны өргөн чөлөө,
“Блю Скай тауэр” 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар, 1024
Утас: 70103131,
Факс: 7010606

ЦАХИМ ХУВИЛБАР
ubinfo.mn
Дугаарын удирдагч
Л.Сугармаа

8680004029112 00852

Цаг үе

Тодорхойгүй бодлогоос үүдэлтэй менежментийн алдаа

Малаа үй олноор устгаж байгаа нь ухаалаг бус шийдвэр юм

Ш.Алтай
ЗГМ

Малын гоц халдварт шүлхий өвчин 2017 оны нэгдүгээр сараас хойш тархаж, улсын гүн рүү нэвтрэн одоогоор нийт 12 аймгийн, 33 сум шүлхийн голомттой байна. Голомтын халдвар авч өвчилсөн 3000 гаруй малыг зориудаар устгаж (2018 оны гуравдугаар сарын 7-ны байдлаар), хорио цээр тогтоон халдваргүйжүүлэлтийн ажил хийгдсээр байна. Түүнчлэн замын хяналтын цэзүүд байгуулж, өөр олон арга хэмжээ авч байгаа боловч өвчний тархалт зогсоогүйгээр барахгүй хяналтанд авч чадах эсэх нь тодорхойгүй байна.

амьд мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг өдөр бүр, янз бүрийн зах зээлд борлуулж байна. Өндөр хөгжилтэй орны фермерүүд гадаадад малын гаралтай бүтээгдэхүүнээ экспортолж ашиг олдог, амьдрал ажил үйлчилгээнийх нь салшгүй хэсэг болдог. Иймд шүлхий өвчнөөс малаа сэргийлж, эрүүл байлгахад онцгой анхаарал хандуулдаг. Шүлхий болон бусад хорио цээртэй өвчнүүдийн халдварыг гаднаас нэвтрүүлэхгүй байхад чиглэсэн байнгын арга хэмжээ авч, өндөр сонор сэрэмжтэй байхыг Засгийн газар нь ч хатуу шаарддаг. Өөрөөр хэлбэл, фермерүүд өөрсдөө шүлхийтэй тэмцэх талаар санаачилга, идэвх зүтгэл гаргаж ажилладаг гэсэн үг. Өвчин гарсан тохиолдолд тэд гэрээт бүтээгдэхүүнээ хугацаанд нь борлуулж чадахгүйд хүрнэ. Үүнээс улбаалан гарах нэмэлт зардал гээд санхүү, эдийн засаг, цаг хугацааны асар их хохирол хүлээдэг байна. Харин манай орны хувьд малчдын сэтгэлгээ болон бизнес

байсан шүлхий өвчин 2000 оноос хойш гарах боллоо. Тухайн үед халдвартай малыг устгаж, эрсдэлтэй малыг вакцинжуулах бодлого хэрэгжүүлснээр дэгдэлтийг амжилттай дарсан байдаг. Гэтэл өнөөдрийн үүссэн нөхцөл байдлыг 2000 оныхтой харьцуулах ямар ч боломжгүй. Иймд одоогийн нөхцөл байдалдаа тохирсон бодлого хэрэгжүүлээгүйгээс шалтгаалж халдвар газар аваад байгааг үгүйсгэхгүй. **Н.Б:** -Цаашдаа Засгийн газар хүний эрүүл мэндэд нөлөөтэй, эсвэл эдийн засгийн их хэмжээний хохирол учруулдаг цөөн тооны өвчнөөс мал сүргийг хамгаалахад малчдад дэмжлэг тусалцаа үзүүлдэг болно. Гэхдээ малаа эрүүл байлгах, ашиг шимийг нэмэгдүүлэх асуудлыг малчид өөрсдөө хариуцдаг болно. Дэлхий дахинд энэ салбарын хөгжил энэ л замаар явж ирсэн туршлага, түүхтэй. Тиймээс одоохондоо Засгийн газар чамгүй мөнгө хөрөнгө гаргаад малын өвчинтэй тэмцэж байгаа энэ богинохон зурвас үед айл өрх

байдлаа үнэлж шүлхийтэй тэмцэх бодлогоо тодорхой болгох хэрэгтэй. Өөрөөр хэлбэл манай улс шүлхийгээс “эрүүлжүүлэх бодлого” хэрэгжүүлж байна уу эсвэл энэ өвчинтэй “тэмцэх бодлого” хэрэгжүүлж байна уу гэдгээ тодорхой болгомоор байна. Хэрэв тэмцэх бодлого хэрэгжүүлж байгаа бол халдвартай малыг устгах шаардлагагүй. Зөвхөн тавилан муутай болсон малыг зовоохгүй гэдэг үүднээс устгадаг шүү дээ. **-Тэгэхээр бид ямар ч үр дүнгүй аргаар, буруу тэмцээд байна гэсэн үг үү?** **Н.Б:** -Шүлхий нь гоц халдварт өвчин. Нэг сүргийн дотор байгаа бүх мал халдвар авах магадлалтай байдаг. Зарим малд биологийнх нь онцлогоос хамаарч эмнэл зүйн шинж тэмдэг хүчтэй илэрдэг. Гэтэл заримд нь шинж тэмдэг бараг илрэхгүй байх жишээтэй. Үнэн хэрэгтээ шинж тэмдэг тод илэрсэн ч бай, сул илэрсэн ч бай халдварт өртсөн бүх мал халдвар тараах эрсдэлтэй. Тиймээс зөвхөн ил шинж тэмдэгтэй малыг ялган

хорио цээрийн чанд дэглэм хэрэгжүүлэх, хилийн хяналтаа сайжруулах, халдварыг эрт илрүүлэх, вакцин хэрэглэх, хүн малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавих замаар эрсдэлтэй бүс нутгаа халдвараас хамгаалах үйл ажиллагаануудыг хэрэгжүүлдэг.

Малчид малын өвчнөөс болж өөрсдөө хохирч байгаа гэдгээ ойлгох нь чухал

-Бодлогын энэ хоёр хувилбарын аль нь манайд илүү оновчтой вэ? **Н.Б:** -Өргөн уудам газар нутагтай, халдвар орж ирж байгаа үүд хаалга нь тодорхой, хязгаарлагдмал байгаа манай улсын тухайд бодлогын энэхүү хоёр дахь хувилбарыг хэрэгжүүлэх нь илүү оновчтой.

-Өвс болон вакцин хийж буй тариураар дамжин халдварлаад байна гэж зарим нь ярих боллоо. Яг шинжлэх ухааны үүднээс тайлбарлаж өгөөч? **Л.А:** -Шүлхий нь богино хугацаанд өргөн уудам нутгийг хамран тархдаг. Тэмээ, үхэр, сарлаг, хонь, ямаа, гахай, буга, зээр зэрэг салаа туурайтныг өвчлүүлдэг гоц халдварт өвчин юм. Шүлхийгээр өвчилсөн бие гүйцсэн малын үхэл хорогдол бага. Халдварын эх уурхай нь халдвар авсан мал, амьтан, тэдгээрийн нус, шүлс, шээс, баас зэрэгтэй хамт ялгаран гарсан вирусээр бохирлогдсон хашаа саравч, өтөг, бууц, ус, тэжээл, бэлчээр, мал, амьтны тоног хэрэгсэл, гутал хувцас зэрэг юм. Шүлхий тариураар тараад байгаа гэж бодохгүй байна, харин өвсөөр дамждаг эсэх асуудал дээр шинжлэх ухааны үндэстэй судалгаа хийж хариулт өгөх хэрэгтэй. Шүлхийн халдвар ихэнхдээ өвчтэй, халдвартай мал амьтнаас шүлхийд мэдрэг мал, амьтанд



Тэгвэл цаашид яах ёстой вэ? Монгол Улс дахь НҮБ-ын ХАА-н хүмүүнлэгийн баг өнгөрсөн долоо хоногт хуралдаж, малын гоц халдварт шүлхий өвчний дэгдэлт, тэмцэх арга хэмжээтэй холбоотой асуудлыг хэлэлцэв. Хурлын үеэр Мал эмнэлгийн ухааны доктор (Ph.D), ХААИС-ийн Мал эмнэлгийн сургуулийн багш Н.Батсуурь, Малын их эмч Л.Амарсанаа нартай ярилцлаа. **-Дэлхийн улс орнууд шүлхий өвчнөөс сэргийлэхэд онцгой ач холбогдол өгч, тэмцдэг. Ийм их анхаардаг шалтгаан нь юу вэ?** **Л.Амарсанаа:** -Шүлхий нь маш хурдан тархаж, эдийн засагт үлэмж хохирол учруулдаг өвчин юм. Тэр ч утгаараа мал нь шүлхий туссан оронд олон улсын худалдааны хориг тавигддаг. Тус улсаас амьд мал болон малын гаралтай түүхий эд, мах экспортлохыг хориглодог журамтай. Иймд мал болон малын гаралтай бүтээгдэхүүнийг бусад улс оронд худалдан борлуулахын тулд тухайн экспортлогч орон шүлхий өвчингүй, тодорхой хэлбэл маш цэвэр байх ёстой. **-Өндөр хөгжилтэй орнууд энэ өвчнийг сайн хянаж, урьдчилан сэргийлж чадаж байна. Энэ юутай холбоотой вэ. Хөрөнгө мөнгө сайтай болохоор тэр үү?** **Н.Батсуурь:** -Судалгаа шинжилгээ, баримт мэдээллээс үзэхэд өнөөдөр дэлхий дахинд гарч байгаа шүлхийн дэгдэлтийн гол голомтууд, эх уурхай нь буурай хөгжилтэй улс, эсвэл мал, амьтны нягтрал өндөртэй улс орнуудад хадгалагдаж байна. Харин өндөр хөгжилтэй орнуудад эрчимжсэн мал аж ахуй жинхэнэ утаараа хөгжсөн байдаг. Тэд олон тооны

ажиллагаанд хараахан ийм нөхцөл бүрдээгүй байна. Өмнөх тогтолцооны үед буюу олон арван жил малын эрүүл мэндийг хамгаалах асуудлыг зөвхөн улс хариуцаж байлаа шүү дээ. Энэ нь нэг талаар нөлөөлж байгаа ч нөгөө талаас эрчимжсэн мал аж ахуйн хөгжил сул зэрэг олон асуудалтай холбоотой юм. **-Ингэхэд манай оронд шүлхийн халдвар яагаад зогсохгүй байна вэ?** **Л.А:** -Нэгдүгээрт, малчид аливаа халдварт өвчний учруулж болзошгүй хор хохирлыг мэддэг, малаа эрүүл байлгах нь ямар ач холбогдолтойг ойлгодог, мэдэрдэг байх нь маш чухал гэж бодож байна. Үүнийг бүрэн ухамсарлаж мэдээгүйдээ ч юм уу, эсвэл хэнэггүй, хариуцлагагүй зангаар асуудалд хандсаар ирлээ. Ийм хуучин дадал зуршлаараа өвчний голомттой газраас дур мэдэн нүүнэ. Эрүүл малтай атлаа өвчин гарчихсан голомт руу нүүж ороод малаа өвчлүүлдэг тохиолдол захаас авчар байна. Мал нь өвчлөөд байхад мэдээлэхгүй, нуун дарагдуулах малаа вакцинжуулалтад хамруулахгүй байх гэх мэт зөрчлүүд байнга гаргаж байна. Зах зээлийн эдийн засагтай манай орны хувьд өмчийн эзэн болсон малчид ийм байж болохгүй л дээ. Эцсийн эцэст малын өвчнөөс болж малчид өөрсдөө маш их хохирч байгаа гэдгээ ойлгохгүй яваад байна. Хоёрдугаарт, Мал эмнэлгийн бодлого тодорхойлдог мэргэжилтнүүд шүлхийн үүсээд буй нөхцөл байдлыг яаралтай үнэлж, хэрэгжүүлж байгаа бодлогоо эргэн харах хэрэгтэй болов уу. 1970-аад оноос хойш гараагүй

бүр малаа эрүүлжүүлээд, өвчнөөс нь салгаад авахын төлөө илүү их мэрийлт, хичээл зүтгэл гаргах цаг болоод байна л даа. Нөгөө талаас Засгийн газрын байгууллагууд малчдад шүлхий өвчинтэй тэмцэх талаар ямар бодлого, тактик барьж байгаа юм, ямар үр дүнд хүрэхийг зорьж буй нь чухал. Түүнчлэн малчид, фермерүүд энэ ажилд ямар үүрэгтэй оролцож, ямар хариуцлага хүлээх юм гэдгийг ил тодоор тайлбарласан сүргэлт сурталчилгааг эрчимтэй хийх шаардлагатай. **-Шүлхийн ил шинж тэмдэгтэй малыг устгаж байгаа нь хэр оновчтой арга вэ. Үр дүнтэй юу?** **Н.Б:** -Шүлхий өвчний талаар улс орон бүр өөрийн гэсэн стратегитэй. Үүнтэйгээ уялдуулж өвчний ил шинж тэмдэгтэй малыг устгах уу, эсвэл устгах шаардлагагүй юу гэдгээ шийддэг. 1974 оноос хойш шүлхий өвчин манай оронд гараагүй байж байгаад 2000 онд анх Дорноговь аймагт бүртгэгдсэн. Энэ үед шүлхий өвчнөөр тайван байсан өөрийн орны статусаа хадгалахын тулд өвчний ил шинж тэмдэгтэй малыг устгах арга хэмжээ авсан. Харин үлдсэн малыг 14 хоногийн зайтай хоёр удаа вакциндаж, хүчтэй дархлаа үүсгэн халдварыг газар авахуулахгүй дарж чадсан түүхтэй. **Л.А:** -Гэтэл өнөөдөр байдал эрс өөрчлөгдөөд байна. Олон жил дараалан шүлхий гарч, шүлхийгүй, эрүүл байсан тусгаа алдсан. Иймд хамгийн хэмнэлттэй, эдийн засгийн үр дүнтэй аргаар уг өвчинтэй тэмцэх хэрэгтэй байна. Хамгийн чухал нь өнөөдрийн нөхцөл

устгах нь өнөөгийн нөхцөлд шинжлэх ухааны үндэслэлтэй арга биш. Сүүлийн үед ил шинж тэмдэгтэй малаа устгуулахгүйн тулд малчид үхэр малаа нуух, өөр тийш нь зөөх замаар шүлхийн халдварыг улам тарааж байгааг үгүйсгэх аргагүй. Манай улс бүхэлдээ энэ өвчний тархалтыг зогсоож, бүрэн эрүүл болгож, түүнийгээ олон улсын хэмжээнд нотолж баталгаажуулах шатанд байгаа бол лабораторийн шинжилгээгээр эерэг урвал үзүүлсэн малаа хүртэл устгах хэрэг гарч болзошгүй юм. Ийм шаардлага хэзээ мөдгүй гарч ирэх ч байх. Тэр үед нь стратегиа тэрхүү зорилгодоо нийцүүлж өөрчилж болно шүү дээ. **-Ер нь дэлхий нийтэд шүлхий өвчний эсрэг ямар бодлого хэрэгжүүлдэг вэ?** **Л.А:** - Шүлхий өвчний эсрэг ямар бодлого хэрэгжүүлэхийг улс орон бүр өөрийн нөөц бололцоо, онцлогтоо тохируулж шийддэг буюу бодлогын олон хувилбар байдаг. Шүлхийтэй тэмцэх бодлогыг дараах хоёр байдлаар ангилж болно. Эхнийх нь шүлхийгүй эрүүл гэсэн статус авах зорилготой бодлого. Уг бодлогыг эрчимжсэн мал аж ахуй өндөр хөгжсөн орнууд ихэвчлэн хэрэгжүүлдэг. Үүнийг шүлхий дэгдсэн тохиолдолд халдвартай болон халдвартай хавьтсан бүх малыг устгах замаар халдварыг зорилго агуулдаг юм. Удах нь шүлхий өвчинтэй тэмцэх буюу шүлхий өвчнөөс учрах нөлөөллийг бууруулах бодлого. Уг бодлого нь шүлхийгээс эрүүлжүүлэх зорилго агуулдаггүй. Тодорхой хэлбэл

Өөрөөр хэлбэл, өвчний халдвар гаднаас нэвтрэн орж ирдэг бүс дэх хилийн сумуудын малд дархлаа үүсгэх замаар байгалийн халдвар дамжин орж ирэхээс найдвартай хамгаалж болно. Одоогийн бидний сул тал нь тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ менежментийн алдаа гаргаж байгаагай холбоотой. Халдварыг нутгийн гүн рүү оруулж, маш их түвэг чирэгдэл үүсгэж, эдийн засгийн асар их үргүй зардал гаргаж байна. Бид гол нь энэ алдааг таслан зогсоох ёстой. Үүнийг Засгийн газар анхаарч, үйл ажиллагаагаа өөрчлөх цаг болоод байна. Манайхаас муу нөхцөлтэй улс орнууд энэ бодлогыг амжилттай хэрэгжүүлж байгаа туршлага зөндөө бий. **-Цагаан зээр шүлхийн халдварыг тараагаад байна гэдэг хэр бодитой мэдээлэл вэ?** **Н.Б:** -Шүлхийн дэгдэлт зонхилон илэрдэг манай орны зүүн бүсэд хил дагуу төмөр торон хашаатай байдаг. Энэ утгаараа зэрлэг амьтан хил дамжин нүүдэллэдэггүй гэсэн үг. Тэгэхээр цагаан зээр шүлхийн халдварыг хилийн цаанаас зөөгөөд авчрах магадлал маш бага юм. Харин цагаан зээр малаас халдвар авч өвчилж байна гэж ойлгох нь зөв. Дэлхий дахинд хийгдсэн судалгаагаар халдвар авсан зээрийн сүрэг халдварыг цааш тараах магадлал маш бага байдаг. Ер нь хотондоо байгаа малаа тариад хамгаалаад байж чадахгүй л байна шүү дээ. Ийм байж зэрлэг амьтад руу бурууг чихэж, зээрээ устгаа гэж байгааг дэлхий дахин яаж ойлгож, хүлээж авахыг хэлж мэдэхгүй байна.

шууд хавьтлын замаар болон вирусээр бохирлогдсон зүйлээр дамжин тархана. Мөн өвчний голомтод ойр байсан мал, амьтанд амьсгалын замаар халдаж болно. Чийглэг, нарны хурц гэрэлгүй, сэрүүн цаг агаартай үед шүлхийн вирус алс хол салхиар зөөгдөн халдварлах эрсдэлтэй. **-Ер нь вакцинжуулалт ямар байдлаар хийгдэж байна вэ?** **Н.Б:** -Вакциныг ихэнхдээ өвчин гарсны дараа хариу арга хэмжээ болгож тарьсан. Өвчний дэгдэлт гарахаас өмнө урьдчилан сэргийлж тариагүй байна. Вакцинд хамруулалт хэсэгчилсэн байдалтай, халдварын голомтын эргэн тойронд сэжиг бүхий олон малыг хамруулалгүй үлдээж байна. Зарим суманд зөвхөн үхрээ вакцинжуулсан байхад зарим нь бог малаа хамруулсан байх жишээтэй. Мөн ихэнх малд вакциныг зөвхөн нэг удаа тарьсан байна. Вакцинжуулалтыг гол нь өвчин гарсны дараа хийх биш урьдчилан сэргийлэх зорилгоор хийдэг байх хэрэгтэй. Аливаа хурдан тархцатгай өвчнүүдийн тухайд өвчин гарсны дараа хариу арга хэмжээ авч байхын оронд өвчний дэгдэлт гарах хамгийн их эрсдэлтэй хугацаанаас өмнө төлөвлөгөөний дагуу бүрэн тарьж дууссан байхуйц хангалттай хугацааны нөөцтэй, жил бүрийн вакцин худалдан авах ажлыг төлөвлөж гүйцэтгэдэг болмоор байна. Улсын хил дагуух бүс нутгаас өөр урьдчилан таамаглаагүй газарт өвчин гарсан тохиолдолд хариу арга хэмжээ авахад зориулж тохирох тун хэмжээний вакцин нөөцөлдөг байх нь зүйтэй.

Тансаг зах зээл

Дэлхийд ердөө наймхан

Захиалгын хослолууд
9-70 сая төгрөгийн
үнэтэй

Б.Бямбасүрэн
@byambaab_ZGM



Тансаг зэрэглэлийн эрэгтэй хослолын зах зээлд дангаар ноёрхож буй “Премьер Тэйлор” ХХК-ийн ерөнхий захирал Т.Зоригттой ярилцлаа. Тэрбээр эрэгтэй хувцас загварын чиг хандлага болон Made to Measure буюу захиалгын хослолын үйлчилгээг энэ удаад онцолсон юм.

-Made to measure буюу захиалгын хослолын үйлчилгээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхгүй юу?

-Дэлгүүрт борлуулж буй 10-20 гаруй төрлийн хослолоос үйлчлүүлэгч өөрт таарч, тохирсноо сонгодог. Харин made to measure үйлчилгээ нь дэлхийн шилдэг 5-10 мянган төрлийн материалаас сонгохын сацуу деталь хэсэг болох товч, доторлогоо, халаас, зах гэх мэт хэсгийг үйлчлүүлэгчийн хүссэнээр хийж өгдөг. Түүнчлэн масс үйлдвэрлэл бус зөвхөн нэг хүнд зориулж, цор ганц хувилбар хийдэг. Үүнд л үйлчилгээний үнэ цэнэ, чанар оршиж байгаа юм.

-Брэндийн онцлог юу вэ?
-Манай “Премьер Тэйлор” компани дэлхийд алдартай Isaia брэндийг албан ёсны франчайз эрхтэйгээр Монголд оруулж ирээд жил гаруйн хугацаа өнгөрлөө. Isaia брэнд нь Италийн Наполи хотоос гаралтай. Түүхэнд гэмдэглэснээр Наполи хот нь Европын төв байсан бөгөөд тэр үеийн хаад маш чамин эд зүйлд дуртай байсан аж. Ингээд дэлхийн гар урчуудыг цуглуулан элдэв чамин урлал хийлгэдэг байснаас үүдэж, өнөөгийн тансаг хэрэглээ гэсэн ойлголт үүсэж, энэ соёл түгэн дэлгэрсээр тансаг, дээд зэрэглэлийн зах зээлийг бүрдүүлж чадсан. Тиймдээ ч тус хотоос гаралтай эдлэл, ялангуяа Наполи хослол чанар, хийцээрээ дэлхийд тэргүүлдэг. Нөгөөтэйгүүр, Наполи нь халуун уур амьсгалтай хот. Тэгэхээр хослолыг халуун газарт яаж тав тухтай өмсгөх ухааныг Италийн хамгийн шилдэг мастер оёдолчид тунгааж, хүний биед хамгийн хөнгөн байлгах тал дээр анхаарчээ.



Захиалсан хослолыг Италийн алдарт Наполи хотод байрлах үйлдвэрт үйлдвэрийн болон гар аргаар оёж, 5-8 долоо хоногт багтаан ирүүлнэ.

вэ?
-Тухайн үйлчлүүлэгчийн юу хүсэж буйг маш сайн мэдэрч, тохирсон шийдэл гаргах нь хамгийн чухал. Жишээлбэл, гаднын оёдолчид Монголд ирэхээр, эсвэл манайхан гадаадад очиж хувцас захиалахдаа өөрийн хүсэж буй зүйлээ гүйцэд ойлгуулж чадаагүйгээс үүдэн үл ойлголцол үүсч, сэтгэл ханамжгүй үлдэх тохиолдол цөөнгүй. Хэмжээ авдаг мэргэжилтнүүд өөрийн гэсэн арга барил, үзэл бодолтой байдаг. Ханцуйг нь богино авах, бэлхүүсийг нь нарийн хийх гэхчилэн өөрийн арга барилаа шингээж хийдэг. Бид сүүлийн таван жил монгол эрэгтэй хүний биеэс стандарт хэмжээ авсан. Тиймээс иймэрхүү ажил эрхэлдэг, тийм насны хүн ийм хэв загвар, өмсгөлтэй байдаг гээд Монголынхоо зах зээлийг мэргэжлийн түвшинд мэддэг болсон. Хамгийн гол нь захиалагчийн биеэс хэмжээ авч, биений онцлогийг нь тусган өөрт нь таарч, тохирсон хослолыг захиалж хийлгэдэг учир сэтгэл ханамж өндөр байх нөхцөл бүрддэг.

-Танайх материалаа хаанаас авдаг вэ?

-“Премьер Тэйлор” дэлгүүрийн хувьд Солонгос, Итали болон Английн алдартай материалын компаниудтай хамтран ажилладаг. Өдөр тутмын болон тансаг зэрэглэлийн материалууд бүгд бий. Харин Isaia брэнд өөрийн гэсэн материалын үйлдвэргүй ч гэлээ дэлхийн шилдэг материал үйлдвэрлэгчид захиалга өгч, зөвхөн брэнддээ тохирсон тусгай

үеийн брэнд. Энэ утгаараа өнгөлөг, шоотой материалыг улирлын коллекцид оруулдаг. Мөн цаг үеийн бус коллекцид цул өнгийн, судалтай классик хэв маяг зонхилно. Isaia-гийн материалыг сүүлийн үеийн технологитой уялдуулдаг. Манай Aqua коллекци нь ус нэвтэрдэггүй, толбо тогтдоггүй гэдгээрээ онцлог. Тиймээс үүнийг бид өдөр тутам хослол өмсдөг хүмүүст болон гоёлын хувцасны сонголтод санал болгодог. Сонирхуулахад, Isaia “соло найм” гэсэн материалыг санал болгодог.

Энэ нь дэлхий дээр ердөө наймхан ширхэг хийгддэг хослол гэсэн үг. Холливүүдийн алдартай оддын хослол хийлгэсэн материалыг бид “соло найм”-аар авч үлдэж, санал болгодог. Энэ материалыг сонгосон тохиолдолд манай брэндийн Ерөнхийлөгчийн гарын үсэгтэй, манай хэд дэх хүн болсныг илтгэх гэрчилгээ олгодог.

-Захиалгын хослолуудын үнэ хэд байдаг вэ. Энэ жилийн хандлага юу вэ?

-Энэ бол маш тансаг зэрэглэлийн үйлчилгээ гэдгийг юун түрүүнд дурдах нь зүйтэй. Манай захиалгын хослолууд 9-70 сая төгрөгийн үнэтэй байдаг. “Премьер Тэйлор”-ийн захиалга нь 3-4, Isaia-гийнх 5-8 долоо хоногт гардаг. Бизнесийнхэн болон улстөрчид нэг их загварын чиг хандлага хөөгөөд байдаггүй. Сүүлийн жилүүдэд бид шоотой материал санал болгож байна. Учир нь өдөр тутам хослол өмсдөг хүн байнгын цулгүй хослол өмсөх нь хэт уйтгартай.

С.Батсайхан / ЗГМӨ



-Isaia брэндийн хослол захиалах шоуны талаар мэдээлэл хүргэхгүй юу. Өмнө нь ийм шоу хийж байсан уу. Гаднаас мастер оёдолчин ирнэ гэсэн?

-Дэлхийн топ таван компанийн нэгэнд зүй ёсоор тооцогддог Isaia брэнд нь тансаг зэрэглэлийн жижиг зах зээл рүү хандсан брэнд юм. Тиймээс хийцийн хувьд бусад брэндээс чанарын өндөр түвшний бүтээгдэхүүн гэдгээрээ онцлог. Isaia брэндийг Монголд оруулж ирээд 1.6 жил болж байна. Энэ хугацаанд бид биеэс хэмжээ авах үйлчилгээг таван удаа амжилттай зохион байгуулсан. Харин энэ сарын 19-21-нд гурван өдрийн шоу зохион байгуулна. Загвар бүрт нэг л мастер оёдолчин байдаг. Бидний хамгийн анхны made to measure үйлчилгээг Isaia брэндийн алдарт мастер оёдолчин, Итали улсад хамгийн үнэ цэнэтэйд тооцогдох “Алтан хайч” шагнал хүртсэн Чанлука Рубино үзүүлсэн. Тэрбээр гурав дахь үеийн алдартай оёдолчин. Энэ удаагийн шоунд тэрбээр дахин оролцохоор болсон.

-Хүний биеэс хэмжээ авах-

даа тухайн хүний юу хүсэж байгааг мэдрэх нь чухал болов уу. Захиалгын үйлчилгээнд хамгийн чухал зүйл юу байдаг

материал захиалдаг. Эрэгтэй хувцасны брэнд классик, загварлаг, орчин үеийн байх ёстой. Isaia бол илүү орчин

Тиймээс саарал дээр ялимгүй шоотой материал илүү тансаг харагдуулдаг. [ЗГМ]

ЭВРИКА

Bloomberg TV Mongolia

“Эврика” нэвтрүүлгээр урлагийн ертөнцийн амин сүнс, цохилох зүрх болсон гайхшруулж, оюун бодлыг сорьж, алмайруулж чаддаг гоц авьяастнуудтай уулзуулдаг. Энэ удаагийн дугаарт Польшийн уран бүтээлч Вильгельм Сасналь оролцоно. Тэрээр олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, гэр бүлийн амьдрал, Польшийн түүхэн дэх хамгийн бүдэг үеийг тодоор дүрслэдэг зураач, кино найруулагч юм. Панкийн эрин үе, Берлины хана нурахад хүүхэд байсан тэрээр орчин үеийн ертөнцийг сонирхохын зэрэгцээ эрх мэдэлтнүүдийн эсрэг хориотой сэдвээр бүтээл туурвихаас айдаггүй нэгэн юм.

Пүрэв гараг /2018.03.15/

20:30

11:30 Баасан гараг

09:30/20:00 Бямба гараг

16:30/22:30 Ням гараг

ZGM DAILY

NSO releases February statistics

Total exports jumped to USD 838.4 million, a USD 13.1 million growth compared to the same period of last year.

Letters between the Presidents of U.S and Mongolia disclosed

Mr. Donald Trump noted that he is delighted to explore ways to expand trade and investment.

Bloomberg Economist Club predicts no change

Experts estimate that the BoM will leave the interest rate unchanged due to the insatisfactory GDP growth.

MSE receives first dual listing request

According to MSE, details of the TSX-listed company is yet to be disclosed.

ZGM: HIGHLIGHTS

POLITICS

Minister of Foreign Affairs Tsogtbaatar Damdin meets his Azerbaijani counterpart Elmar Mammadyarov to exchange views on bilateral ties and cooperation in Baku, Azerbaijan. Within the frame, a memorandum of understanding on cooperation signed between the two countries.

A national consultative meeting for officials of the Ministry of Social Welfare and Labour takes place.

ECONOMY

Mongolian Stock Exchange receives the first dual listing request from a TSX-listed company.

The IPO of ‘LendMN BBSB’ JSC to commence the secondary market trading today.

Darkhan-Selenge Electricity Distribution Network JSC decides to distribute dividends worth MNT 56.64 per share from net profit of 2017, which will be paid starting from July 17 at the company’s office.

Top 20 Index falls by 0.09 percent, to 20774.30. MSE A Index grows by 0.23 percent, to 10330.94. MSE B Index rises by 0.51 percent, to 9935.35. Market cap stands at MNT 2.51 trillion.

SOCIETY


Co-organized by the Government of Mongolia and the Partnership for Action on Green Economy, Partnership for Green Economy week commences until March 17.

An exhibition named ‘Human’ which comprised of total 49 portraits of ‘100 esteemed persons of Mongols’ guests TV program, at the Mongolian National Modern Art Gallery.



OUTLOOK

Bloomberg TVM: Interest rate to remain unchanged



Oyunbayar.N
ZGM

Experts from the Bloomberg economist club believe the Monetary Policy Council will not change interest rate of the Bank of Mongolia (BoM) this month. In other words, majority of experts predicted that the interest rate will remain at 11 percent. They view that the GDP growth is in satisfactory level and the BoM signifies to keep the MNT rate stable.

The current interest rate, of which the council lowered the interest by one percent in December 2017, is 11 percent. At the time, the BoM highlighted that the decision will support economic growth, business revival and employment. Looking at the indicators since then, the nationwide inflation rate increased to 6.9 percent, below the BoM’s target level as of January. In addition, the unemployment rate has been decreased to 7.3 percent. Bayartsaikhan Nadmid, Governor of the BoM, notified that although the majority of macro indicators have shown higher results, it is yet to relax. In 2017, he evaluated that it was “a year we escaped from a default.”

Amar Lkhagvasuren, an economist at the Asian Development Bank, expressed that he has a positive prediction for economic indicators this year. [ZGM]

Budget ends February with USD 73.1 billion surplus

Budget deficit lowered by 82.5 percent year over year

Tugsbilig.B
ZGM


National Statistics Office released the results of socio-economic situations of February 2018. According to the report, trade surplus resulted USD 112.4 million, which is 67.4 percent lower in the year over

year comparison, while the trade turnover reached USD 1.6 billion, a 18.9 percent growth compared to the corresponding month of 2017. Minerals export revenue stands at approximately USD 690.6 million, of which coal exports made up USD 245.4 million (MNT 5.3 billion). Total exports jumped to USD 838.4 million, a USD 13.1 million growth compared to the same period of last year. The key factor for the growth was USD 41.4 million growth of gold export. Budget deficit reduced by 4.9 percent thanks to the reduced loan pressure, which lowered by 82.5 percent year over year.

Budget revenue raised by 29.1 percent, to MNT 1.1 trillion. Specifically, income tax, VAT, foreign operation and social insurance revenues contributed significantly, displaying MNT 73.1 billion surplus. In addition, national consumer price index for goods and services jumped by 6.9 percent over last year’s corresponding period. The growth was mainly due to changes in prices of main consumer goods, namely food products, beverages, tobacco, vegetables, accommodation, electricity, medicines and medical services. Money supply reached MNT

15.9 trillion in February, displaying MNT 135.5 trillion increase compared to January. The currency issued in circulation totalled MNT 850.4 billion last month, a five percent increase compared with the previous month. In the monthly comparison, the USD/ MNT rate raised by three percent, to 2402.9 units, while MNT picked up against CNY by 5.5 percent in the year over year comparison. Unemployment fell by 27.8 percent over the corresponding month of last year. The average monthly salary stands at MNT 1 million, a 10.2 percent growth in yoy. [ZGM]

STATISTICS



FOREIGN RELATIONS

US President replies to The President of Mongolia



is proud to be Mongolia’s trusted “third neighbor,” and we appreciate Mongolia’s support as we work together to address regional and global challenges.”

Both presidents noted that the current economic relations of the two countries has not reached to its full potential.

According to the statistics provided by the President of Mongolia in his letter, the size of the two countries’ trade is at a level that reaches not even two percent of Mongolia’s overall foreign trade. Since 1990, just over USD 300 million has been invested into Mongolia from the United States.

President of Mongolia expressed that he hopes Mr Trump to help Mongolia to solidify its economic security through utilizing America’s development finance tools, and make a significant difference through intensifying bilateral economic relations that are, in his view, not sufficiently robust.

Mr Battulga highlighted that Mongolia needs a tangible economic support from the United States. More specifically he requested Mr Trump to provide an improved access for



Mongolia’s textile products export into America’s market within the existing trading system. He believes this will make a significant impact on the reduction of unemployment among Mongolia’s women.

President Trump noted that he is delighted to explore ways to expand trade and investment on a fair and reciprocal basis. In doing so, the Mr. Trump wrote that the United States trade and investment agencies, such as the United States Overseas Private Investment Corporation, are interested in expanding business opportunities in Mongolia, especially in the agricultural and renewable energy sectors. Additionally, he views that the upcoming Millennium Challenge Corporation compact should help create economic growth in Ulaanbaatar. [ZGM]

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2018 оны 03 дүгээр сарын 14-ны өдөр

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: Камерын систем нийлүүлэх
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: ХО-2018/009

“ДЦС-4” ТӨХК нь эрх бүхий тендерт оролцогчдоос Камерын систем нийлүүлэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу.

Тендерт оролцогч нь тендер илгээхийн өмнө 50.000 /тавин мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн жил бүрийн борлуулалтын орлого нь санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна. /2016 он, 2017 он/

2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна.

3. Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажил: Сүүлийн 2 жил буюу 2016, 2017 онд ижил төстэй гэрээт ажил гүйцэтгэсэн байна.

Тендерийн хамт 2% үнийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Засгийн газрын бондоор ирүүлсэн тендерийн баталгааг хүлээн зөвшөөрнө.

Тендерийг 2018 оны 04 дугаар сарын 16-ны өдрийн 10.00 цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг 2018 оны 04 дугаар сарын 16-ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Монгол улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, Эрчим хүчний гудамж, “ДЦС-4” ТӨХК-ийн Захиргааны байр, 3 дугаар давхар, 312, 313 тоот өрөө Худалдан авах ажиллагааны хэлтэс Утас 7018-1309, 7000-1357, 7017-1357, Факс 7018-1309 7000-1357

Өдрийн хэмнэл

ТВ ХӨТӨЛБӨР

09.45	“Урлаг” теле сэтгүүл
11.00	“Монголын мэдээ” мэдээллийн хөтөлбөр
14.00	“Нууц шифрийн учир” УСК 5, 6-р анги
18.30	Олон нийтийн цаг
21.05	“Нээлттэй хэлэлцүүлэг”
22.10	“Екатерина” олон ангит УСК 7-р анги

Bloomberg TV Mongolia

07.30	“Цахиурын хөндийгөөс цааш” нэвтрүүлэг
11.30	“Бүрэн тайлбар” нэвтрүүлэг
14.00	“Танилц: Япон” нэвтрүүлэг
17.00	“Bloomberg Surveillance”
20.00	“Блумбергийн ярилцах цаг” нэвтрүүлэг
22.00	“Технологийн шийдэл” нэвтрүүлэг

БОЛОВСРОЛ HD

07.50	“Монголчууд нийгэм журамд давшин орсон нь” 13-р цуврал
11.25	Үүнийг хэрхэн хийдэг вэ
14.40	“Nous tech” танин мэдэхүйн нэвтрүүлэг
18.05	“Бяцхан оцон шувуу Пороро” хүүхэлдэйн кино
20.50	“80 саяын уналт” асуулт хариултын шоу нэвтрүүлэг
22.00	“Көсөм” ОАК 2.51-р анги

МОНГОЛTV

06.30	“Өнөө өглөө”
11.40	Үлгэрийн цаг 32-р хэсэг
14.00	“Хүрээлэн амьд ертөнц” 75-р хэсэг
17.30	“Пэппа торой” хүүхэлдэйн кино
19.30	“Мөрдөгч хүүхдүүд” ОАК (season-1) 65, 66-р анги
22.30	“Empire” ОАК (season-1) 5-р анги

ЗУРХАЙ



Билгийн тооллын 27
Хаврын тэргүүн хөх бар сарын таван шар мэнгэтэй, хөхөгчин могой өдөр.
Үс засуулбал: Өлзийтэй сайн
Наран ургах, шингэх: 07.08-18.52
Барилдлага: Идэр
Шүтэн барилдлага: Тийн мэдэхүй
Суудал: Шороо

Аргын тооллын гуравдугаар сарын 14, Буд гараг. Билгийн тооллын 27, Булагч бидтой, хөхөгчин могой өдөр.
Өдрийн наран 07.08 цагт мандаж, 18.52 цагт жаргана. Тухайн өдөр үхэр, тахиа жилтнээ аливаа үйл хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эе, эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, сүм дугана сэргээх, газар лусын зан үйл хийх, өр барагдуулах, буг дарах, газрын ам бооход сайн. Ургаа мод таслах, газрын ам нээх, гөлөг тэжээх, байшингийн суурь тавих, угаал үйлдэхэд муу. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээл-гэх буюу засуулбал өлзийтэй сайн.

ОНЦЛОХ ҮЗВЭР

Улаан өндөгний эрэлд



IMAX



Гайхамигч үрсэлмэлсэр

Найруулагч Стивен Спилбергийн бүтээл “Ready Player One” кино дэлхий дахинд нээлтээ гуравдугаар сарын 30-нд хийх гэж байна. I Max-ын дэлгэцнээ уг кино гарч эхлэх юм. 140 минут үргэлжлэх шинжлэх ухааны уран зөгнөлт энэхүү киног “Warner Bros” компани бүтээжээ. 2045 онд дэлхий ертөнц хүн амын илүүдэл, авлига, цаг уурын өөрчлөлтөөс болж яг л ядуусын хороолол шиг болно. Хүмүүс хоосрол, гуйланчлалаас зугтахын тулд ажиллах, сурах, зугаацан цэнгэх боломжтой виртуал ертөнц OASIS-д татагдан ордог. Гэтэл Уэйд Уотсон хэмээх өсвөр насны хүү Улаан өндөгний баярын өндөг олох тоглоомонд өрсөлдөхөөр шийднэ. Уг тоглоомын ялагч OASIS-д 500 тэрбум ам.долларын өмч хөрөнгөтэй болох эрх авдаг аж. Энэхүү кино зөвхөн нээлтээ хийсэн өдрөө 35 сая ам.долларын орлого олно гэж Канад, Америкимйн шинжээчид таамаглаж байна. [3ГМ]



“Цэргийн бодол” тоглолт
Хэзээ: 2018.03.17-ны 19.00 цагт
Хаана: Улаанбаатар палас
Тасалбарын үнэ: ₮30 мянга



“Дон Кихот” балет
Хэзээ: 2018.03.17-18-ны 17.00 цагт
Хаана: УДБЭТ
Тасалбарын үнэ: ₮10-20 мянга



“Алсын газрын зэрэглээ” концерт
Хэзээ: 2018.03.27-ны 19.00 цагт
Хаана: УДБЭТ
Тасалбарын үнэ: ₮30-40 мянга

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ

1			2		
4					
5	6			7	
9					10
11					
12			13		

БОСООГООР:

1. Үрэлтээс үүссэн үйрмэг
3. Түүхэнд алдаршсан “Марзан” хэмээх зураач
4. “Чингис хаан” одонт дуурийн од
7. Шведэд суугаа Монгол Улсын Элчин сайд
8. Өвөр Монголын аймаг

10. Энэтхэг улсын Ерөнхий сайд асан эмэгтэй
11. Дугуйт тэшүүр

ХӨНДЛӨНГӨӨР:

1. Ижий гэсэн хуучин монгол үг
2. Олон янзын өнгөтэй чулуулаг эрдэс
5. Үндэсний үзэл, хандлагаараа буруудан хорлогдсон

6. Ардын төрийн наад-мын анхны түрүү бөх
9. Эвтэй дөрвөн амьтан
10. Европ, Африкийг зааглах хоолой
12. Нийслэлийн ойролцоох хүүхдийн олон улсын зуслан
13. Хоол, хүнс
14. Зарим улс орны мөнгөний нэгж

Өмнөх дугаарын хариу

	О	С	Е	Й	Ш	Е	Л	Ь	А	
Х		Р	Х		Е		И	Д	Д	
И			О		К		А		У	
Н	О	Р	О	В	С	А	М	Б	У	У
Д		Д			П		О		Л	
И	О	Г		И		С	Р		Ь	
Н	Х	О	О	Р	М	О	Г		А	

ЗГМ: СУДОКУ

7			9			2	6
2	5		4			8	
		8	6		5	7	
		1	5		9	6	
9		2		3			1
	6	7	8		3		
		3	9		2	8	
	1				6		3
5	7		1				4

3	6	5	1	2	8	7	4	9
1	2	8	4	9	7	6	5	3
9	4	7	5	6	3	8	1	2
4	5	1	2	8	9	3	6	7
2	3	9	7	4	6	1	8	5
8	7	6	3	1	5	2	9	4
7	9	2	8	5	1	4	3	6
5	8	4	6	3	2	9	7	1
6	1	3	9	7	4	5	2	8

(Өмнөх дугаарын хариу)



ГАЛТ ТЭРЭГНИЙ ЦАГИЙН ХУВААРЬ

МОСКВА-УБ	21.35	07.30
УБ-ЭРХҮҮ	21.10	02.40
ЭРХҮҮ-УБ	15.35	06.20
УБ-ЗАМЫН-ҮҮД	20.00	07.50
ЗАМЫН-ҮҮД-УБ	21.35	09.55
УБ-ЭРДЭНЭТ	20.30	07.45
ЭРДЭНЭТ-УБ	19.10	05.48
УБ-СҮХБААТАР	10.55	19.52
СҮХБААТАР-УБ	06.30	15.35
САЙНШАНД-УБ	20.25	07.01
УБ-САЙНШАНД	09.15	19.15
ЗҮҮНХАРАА-УБ	04.25	08.40



НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-ХАНБУМБАТ	07.00	08.10
ХАНБУМБАТ-УБ	09.00	10.05
УБ-СӨҮЛ	07.40	12.00
СӨҮЛ-УБ	13.20	16.05
УБ-БЭЭЖИН	08.15	10.30
БЭЭЖИН-УБ	11.30	14.00
УБ-ТОКИО	08.55	14.30
ТОКИО-УБ	15.30	20.25
УБ-БАНГКОК	17.30	22.50
БАНГКОК-УБ	23.50	07.00 (+1)
УБ-ХАНБУМБАТ	20.00	21.10
ХАНБУМБАТ-УБ	22.00	23.05



Г.МӨНГӨНТУЯА

Хүнд машин, механизмын оператор “Оюу толгой” ХХК, Ил уурхай

Өмнөговь аймгийн Ханбогд сумын уугуул. Тэрээр нэг удаадаа 300 тонн хүдэр тээвэрлэх хүчин чадалтай “Комацу 930Е” машины оператороор Ил уурхайд гуравдахь жилдээ ажиллаж байна.

“ОЮУ ТОЛГОЙ” КОМПАНИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ 24 ХУВИЙГ ЭМЭГТЭЙЧҮҮД ЭЗЭЛДЭГ НЬ ДЭЛХИЙН УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ДУНДЖААС (8-13 ХУВЬ) ДЭЭГҮҮР ҮЗҮҮЛЭЛТ ЮМ.

“Оюу толгой” болон гэрээт компаниудын шинээр зарласан ажлын байрны талаарх мэдээллийг <http://ot.mn/ажлын-байрны-зар/> холбоосоор авна уу.

Эрдэм мэдлэг, ур чадвар, үнэт зүйлс бүтээлцэнэ.



Оросыг халдлагад буруутгаж, хориг тавихаа мэдэгдлээ

Британийн Ерөнхий сайд Английн Салисбери хотод сэтгэгцэд нөлөөлөх бодисоор балмад, хэнэггүй халдлага хийлээ хэмээн буруутгав. > 10

Японы Сангийн яам баримтаа зассан байна

Японы Сангийн яам Ерөнхий сайд Шинзо Абэ болон түүний эхнэрийн нэрийг хассан хуурамч баримт үйлдсэнээ хүлээн зөвшөөрөв. > 10

Өмнөд Солонгосын ахмадууд залуусаас илүү ажилладаг

Статистикаас үзэхэд Өмнөд Солонгост эдийн засгийн идэвхтэй 60 дээш насны хүмүүсийн тоо хориод насныхнаас давжээ. > 10

Том компаниуд 10 жилийн өмнөхөөс бага татвар төлдөг нь илчлэгдлээ

Рошель Топленский


Үндэстэн дамнасан том компаниуд 2008 оны санхүүгийн хямралын өмнөх үетэй харьцуулахад харьцангуй бага татвар төлж байгаа нь Financial Times-ийн судалгаагаар тогтоогдлоо. Уг судалгаа нь төсвийн алдагдлаа багасгаж, татварын шинэчлэл өрнүүлэх Засгийн газруудын хүчин чармайлт нь компанийг хөндөж чадахгүй байгааг харуулав.

Тайландаа тусгасан, татвар төлөх ёстой орлоготой нь харьцуулсан татварын хэмжээг илэрхийлдэг Effective Tax Rate буюу татварын жинхэнэ хувь хэмжээ санхүүгийн хямралаас хойш есөн хувиар буурчээ. Бүр татвараас зайлсхийх явдалтай тэмцэл өрнүүлсээр байхад шүү.

Засгийн газрууд компанийн татварын хэмжээг багасгасан нь дээрх бууралтын ердөө хагастай нь холбоотой. Хамгийн гол нь үндэстэн дамнасан компаниуд татвараар чангалах бодлогоос урьтаж чадаад байгаа бололтой.

Financial Times үйлдвэрлэл, технологийн есөн салбарт хөрөнгийн үнэлгээгээр тэргүүлдэг, хувьцааг нь нээлттэй арилждаг дэлхийн 10 том компанийн сүүлийн 25 жилд төлсөн татварын хэмжээг шалгаж үзлээ. Мөн оффшорт бэлэн мөнгө хамгийн их хуримтлуулсан, үндэстэн дамнасан 10 том компанийн төлсөн татварыг тооцоолов.

Орлогод ногдох татварын хувиар тооцвол төрийн санхүүд оруулдаг хувь нэмэр нь 2008 оноос хойш буурчээ. Нөгөөтэйгүүр татварын нэг хэсгийг төлчихвөл үлдсэнийг



нь хойшлуулах боломжийг компаниудад олгодог зохицуулалт нь жинхэнэ хувь болон бодитой төлж буй хэмжээ он онд эрс ялгаатай гарах нөхцөл бүрдүүлж байна.

Урт хугацаанд авч үзвэл бүр тодорхой. Компаниудын төлдөг татварын жинхэнэ хувь 2000 оноос хойш гуравны нэгээр буюу 34-өөс 24 хувь болтлоо багассан байна.

“Тодорхой, бодитой олон арга хэмжээ авсан ч байдал тэс өөр. Төлөх татварын хувь хэмжээг бууруулах, оюуны өмчийг татвараас чөлөөлдөг

патентын хөнгөлөлт эдлүүлэх явдал компанийн татварын тогтолцоонд ноёрхож байгаа”-г Харвардын их сургуулийн санхүү, хуулийн ухааны профессор Михир Десай тайлбарлав. “Доог тохуу болон хоёр нүүртгүй арга хэмжээний аль нэг нь” хэмээн тэрбээр ярьсан юм.

Санхүүгийн хямралаас хойш технологи, үйлдвэрлэлийн гол компаниудын татварын жинхэнэ хувь 13 орчим хувиар унасныг FT-ийн судалгаа харууллаа. Ийм хандлага эрүүлийг хамгаалах болон өргөн хэрэглээний бараа

бүтээгдэхүүний салбарт ч илэрч байна.

Санхүүгийн хямралын дараа хэрэглэгч, ажилчдынхаа татварыг нэмсэн Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (ЭЗХАХБ) гишүүн улсууд татвараа бууруулсаар байгааг судалгаа харуулав.

Компаний татвараа 2008 оноос хойш таван хувиар бууруулсан улс орнуудын Засгийн газар хувь хүмүүсээс авах татвараа зургаан хувиар ихэсгэснийг бүртгэл тооцооны KPMG компанийн статистик баталж байна.

“Засгийн газруудын энэ өрсөлдөөн лав зогсохгүй” хэмээн Оксфордын их сургуулийн бизнесийн татварын судалгаа хариуцсан профессор Майкл Деверю өгүүлэв. Саяхан АНУ компаниудаас авах суурь татвараа багасгасан нь Засгийн газруудын татварын өрсөлдөөнийг ширүүсгэж болзошгүй хэмээн профессор таамагласан юм.

Татварын хууль журмыг хялбарчлах зорилгоор ЭЗХАХБ, Их 20-иос арван жил өрнүүлсэн ажил үндэстэн дамнасан компаниудад татварын дансаа

багасгах нөхцөл бүрдүүлсэн нь гайхал төрүүлж байна.

Улс орон бүр компаниас авах татварын хувь хэмжээг өөрсдийн үзэмжээр тогтоох эрхтэй учраас олон улсын татварын тогтолцооны шинэчлэл чухал хэмээн Европын холбооны татварын хэрэг эрхэлсэн комиссар Пьер Московичи өгүүллээ. “Алдаа гаргахаа больцгооё. Татвараас бултах, татварын өгөөмөр төлөвлөлт үүсгэх нөхцөл нь суурь татвар биш. Ашиг шилжүүлэх орчин бүрдүүлдэг тогтолцоо үүнд буруутай” хэмээн тэрбээр тайлбарлав.

Apple, Google, Amazon зэрэг группийн татварын хэрэгтэй холбоотойгоор “ашиг шилжүүлэх” тогтолцоог устгах нь чухал боллоо.

Судалгаагаар технологийн том компаниуд гадаадад олсон орлогодоо дотоодод олсноосоо маш бага татвар төлдөг нь илрэв. Уг бүлэгт багтсан компаниуд хуулиар шаарддаг бүх татварыг төлдөг гэж тайлбарласан. Зарим нь татварын шинэчлэл шаардлагатайг ч хүлээн зөвшөөрч байна.

Татвараас бултах явдлыг зогсоох зорилгоор ЭЗХАХБ-аас гаргасан 15 оноогоор үнэлэх төлөвлөгөөг улс тус бүр хуульдаа тусгаж, хүчин төгөлдөр болж эхэллээ. Үндэстэн дамнасан компаниуд ашиг шилжүүлэхэд ашиглаж ирсэн компани хоорондын зээлийг зогсоох шинэ хязгаарлалт “үр дүнгээ өгч чадах эсэхээ ирэх жилээс харуулна” хэмээн ноён Деверю таамаглаж байна.



Шиньжян-Уйгурт аюулаас хамгаалах зардал эрс өсөв

Эмили Фэн

Үндэсний цөөнх, ялангуяа ислам шашинт уйгурчуудыг БНХАУ хатуу гараар цагдаж буй. Тиймээс Шиньжян-Уйгурын бүс нутагт аюулаас хамгаалах зардлаа жилийн дотор хоёр дахин өсгөв.


Нийгмийг аюулаас хамгаалах зардал нь жилийн дотор 92 хувиар өсөж, 57.95 тэрбум юань буюу 9.16 тэрбум ам.долларт хүрснийг тус өөртөө засах орны захиргаанаас гаргасан статистикаас харж болно. Энэ өсөлт БНХАУ-ын аюулаас хамгаалах зардлын нийт өсөлтөөс найм дахин их байгаа юм. Сүүлийн арван жилд 10 дахин ихэссэн Шиньжян-Уйгурын аюулаас хамгаалах зардал өсөлтийн үзүүлэлтээр Хятадын бусад өөртөө засах орон, мужийнхаас хавьгүй их байна.

Энд тогтоосон аюулгүй байдлын хатуу хяналт цаашид нийт Хятадыг хамарч болзошгүй хэмээн түгшдэг ажиглагч олон. Өнгөрсөн долоо хоногт чуулсан Бүх Хятадын ардын төлөөлөгчдийн Их хурлын ээлжит чуулганы үеэр гаргасан тайлангаас үзвэл БНХАУ-ын нийгмийг аюулаас хамгаалах зардал өнгөрсөн онд 1.24 их наяд юань болсон нь 2016 оныхоос 11.4 хувиар өссөн байв.

Нийгмийг аюулаас хамгаалах зардал батлан хамгаалах зардлаас даруй 20 хувиар илүү өслөө. Дотоодын аюулаас хамгаалах зардал Өрөмч хотод үндэсний цөөнхийн цуст бослого дэгдсэн 2010 онд анх удаа батлан хамгаалах зардлаас давсан юм.



BBM©



Аюулаас хамгаалах зардал 2016 онд Шиньжян-Уйгурын өөртөө засах орны намын хорооны нарийн бичгийн даргаар

томилогдсон Чэн Чуньгуо цагдан хянах нүсэр тогтолцоо байгуулсан үеэс ихэссэн юм.

Өмнө нь Төвөдийн өөртөө

засах орны намын хороог тэргүүлж байсан ноён Чэн гэгч Шиньжянд ирмэгцээ 11 сая уйгур иргэний паспортыг шууд

хураасан. Тэрбээр шашны зарим ажиллагааг хориглож, олон мянган уйгурыг шинээр байгуулсан засан хүмүүжүүлэх газарт илгээсэн.

“Өссөн зардлыг Шиньжянд хаа сайгүй байдаг цагдан хянах, шалган нэвтрүүлэх тогтолцоонд 2017 онд дайчилсан 100 мянган шинэ цагдаагийн цалин болон олон зүйлд зарцуулна” хэмээн ХБНГУ дахь Европын соёл, шашин судлалын сургуулийн багш Адриан Зенц тайлбарлав.

Дарамт шахалт энэ онд чангарч, Хятад улсад үнэнчээ байнга мэдэгддэг, зарим нь ХКН-д албан тушаалтай удирдагч, нэр алдартай сэхээтнүүдийн дунд хүртэл цэвэрлэгээ явуулсан гэх мэдээ байна.

“Анх гадаадад зорчсон хүн бүрийг мөрддөг байв. Сүүлдээ хэрэгт холбогдож байсан хүмүүсийг ч бас мөрддөг болсон. Одоо бүр зохиолч, сэхээтэн олон хүнийг хараалчихлаа” хэмээн АНУ-д орогнох хүсэлт гаргаад буй уйгур шүлэгч, кино найруулагч Тахих Намут яриу.

Энэ оны эхээр Шиньжяны их сургуулийн удирдлага, Шиньжяны хэвлэлийн хорооны захирал, орлогч захирал нарыг албан тушаалаас нь огцруулж, баривчилсан тухай эх сурвалж мэдээллээ. Мөн Шиньжяны боловсролын хорооны дээд албаны хүнийг баривчилжээ. Баривчлагдсан хүмүүсийг бага, дунд сургуулийн сурах бичиг алдаатай хянасан хэрэгт буруутгаж байна.

Нэгдүгээр сард Шиньжяны алдартай яруу найрагчийг албадан

саатуулсан тухай шүлэгчийн найз нөхөд мэдээлэв. “Эх оронч сэхээтний хувьд эрх баригчдын байр сууринд харш онлайн юм уу компьютер өгөгдлөөс улбаалж баривчилсан бололтой” хэмээн Вашингтоны их сургуулийн антропологич, Шиньжян судалгаагаар мэргэшсэн Даррен Байлер таамаглав.


Орон нутагтаа нэр хүндтэй байсан ч эрх баригчдын хяналтаас мултрах аргагүй. Уйгур рэппер Аблажаныг саяхан баривчилж, дахин хүмүүжүүлэх лагерьт илгээснийг ах нь мэдээллээ.

Үүний зэрэгцээ Хятадад тархсан айдас хэдийнэ тус улсын хилээс давсныг гадаадад амьдардаг уйгурчууд тайлбарлав. “Хэрвээ би ноцтой утгатай том хэмжээний нийтлэл бичиххвал Шиньжяны цагдаагийн газар шууд аав ээж рүү минь утасдаж сүрдүүлнэ” хэмээн Вашингтон дахь АНУ-ын санхүүжилттэй “Чөлөөт Ази” радио станцын уйгур сурвалжлагч Гульчера Хожа ярьсан юм.

Гурван жилийн өмнө Хятадын олон нийтийн мэдээллийн хэрэгслээр өөрт нь богино мессеж илгээсэнээс үүдэн хатагтай Гожагийн садан төрлийн 20-иод хүн баривчлагдаж, сураггүй болсон. Тэрбээр садан төрөл нь энэ онд сураг тасарсан “Чөлөөт Ази” станцын зургаан уйгур сурвалжлагчийн нэг юм.

“Хүмүүс надтай ноёрхлохоос айдаг. Надтай найзалснаас үүдэн ар гэрийнхнийг нь шийтгэх вий гэхээс айцгааж буй хэрэг” хэмээн сурвалжлагч тайлбарлав.





BBM©

Жорж Паркер

Британийн Ерөнхий сайд Тереза Мэй Английн сүм хийдийнхтэй болсон Салисберид сэтгэцэд нөлөөлөх бодисоор балмад халдлага хийлээ хэмээх буруутгаав. Уг явдлын учир шалтгаан нь Оросын давхар тагнуулч Сергей Скрипал, охины хамт эмнэлэгт маш хүнд байдалтай хүргэгдсэнтэй холбоотой юм. Хатагтай Мэй Төлөөлөгчдийн танхимд хэлсэн үгэндээ Кремлийг хатуу эмлэж, тагнуулч асан Скрипалыг Орос болговсруулсан цэргийн зориулалттай Новичок хэмээх сэтгэцэд нөлөөлдөг бодисоор хордуулсан хэмээн мэдэгдэв. Тэрбээр “Манай Засгийн газар Сержей ба Юлия Скрипал нарын эсрэг үйлдэлд Оросыг буруутай гэх маш өндөр магадлал бий” гэжээ. Тэрбээр цагдаа биологийн шинжээчид, Британийн цэргийн химийн зэвсэглэлийн судалгааны төвийн долоо хоног хийсэн мөрдөн байцаалтын дүгнэлтээс эш татсан байна.

Хатагтай Мэй уг асуудлыг ирэх мягмар гараг хүртэл тайлбарлах хугацаа өгөөд үгүй

бол Ерөнхийлөгч Владимир Путин Засгийн газрын эсрэг өргөн хэмжээний хориг тавих болно хэмээн мэдэгдлээ. Тэрбээр “Төлөөлөгчдийн танхимд үнэмшилтэй хариу өгөхгүй бол үүнийг Нэгдсэн вант улсын эсрэг хууль бусаар хүч хэрэглэсэн явдал гэж үзэх болно” гэжээ. Оросын Гадаад хэргийн яам Мэйгийн мэдэгдлийг “Британийн парламентад дэх циркийн тоглолт” хэмээн үл тоов. Тус яамны хэвлэлийн төлөөлөгч Мария Захарова “Дүгнэлт нь илэрхий, өдөөн хатгалбал суурилсан бас үл төрийн өнгө аяс” гэжээ.

Хатагтай Мэй энэ сарын 4-нд Салисбэрид халдлагатай өртсөн Скрипалын мөрдөн байцаалтыг танилцуулахад Төөлөгчдийн танхим анхир чимээгүй сонссон байна. Оросын тагнуулч асан Скрипал гэгч Британийн М16 тагнуулын газарт мэдээ дамжуулж, дараа нь солилцоогоор унд ирсэн хүн. Мэй цааш нь Британи дахь

Оросын Элчин сайд Александр
Яковенког Гадаад хэргийн
яаманд дуудан ирүүлж, уг

халдлагын талаар Оросын тал юу мэдэж байгаагаа тайлбарлахыг шаардсан 36 цагийн шаардлага тулгарсан гэж мэдээлэв. Тэрбээр “Энэ бол Оросын зүгээс манай эсрэг хийсэн шууд халдлага эсвэл Оросын Засгийн газар асар аюултай бодисоо хяналтаасаа алдаж, өөр нэгний гарт оруулсан явдал” гэсэн байна.

Сөрөг Лейбор намын тэргүүн Жереми Корбин Ерөнхий сайдад хандаж, АНУ-ын Магнитскийн хуультай адил арга хэмжээг хоригт оруулахыг шаарджээ. Энэ нь хууль эрхийг зөрчсөн Оросын харьяатуудад виз олгохыг хориглож, хөрөнгийг хураах арга хэмжээ юм. Ноён Корбан оросууд Консерватив намд 800 мянган паунд өгсөн учир Мэй Оросын олигархууд болон тэдний хамаатнуудыг онилохоос түдгэлзэж байна хэмээн буруутгаж, “Ичгэвтэр хэрэг, шившиг” гэж хашигч байв. Хатагтай Мэй Лондонд амьдарч байгаа оросуудыг “ижил багсаар будаж болохгүй” гээд харин Путины хамаатнуудыг шийтгэх Лейборуудын саналыг дэмжихээ илэр-

хийлжээ. Түүний Засгийн газар Магнитскийн нэмэлтийг батлахын тулд намуудтай зөвшилцөхийг санал болгосон бөгөөд хүний эрхийн зөрчлөөс шалтгаалан хөрөнгө хураахыг олонх нь дэмжих байх гэж эрх баригч намын албаны хүн ярьсан байна.

Москвагийн эсрэг Лондоны авах арга хэмжээний нарийн зүйл тодроогүй боловч Оросын дипломатууд албадан гаргах асуудал хөндөгдөж магадгүй. Британийн Гадаад хэргийн яам энэ жил Ороост болох Хөл бөмбөгийн ДАШТ-д Английн багийн оролцуулахгүй гэсэн төлөвлөгөө байхгүй гэжээ. НАТО-гийн Ерөнхий нарийн бичгийн дарга Жинс Столтенберг “Сэтгэцийн бодис ашигласан нь аймшигтай, хүлээн зөвшөөрч болшгүй үйлдэл. Их Британи өндөр үнэлэгддэг холбоотон учир энэ хэрэг явдал НАТО-гийн сэтгэлийг ихээхэн түгшээж байна. Тус эвслийн албаныхан Британитай уг асуудлаар ярилцсан” гэв.

учраас нууцалсныг илрүүлэхэд
ханаарна. Ноён Абэ бүрэн
шалгалт хийхээ амлаад “Энэ
нөхцөл байдал манай төрийн үйл
ажиллагаанд эргэлтээ төрүүлэх
учир хариуцлагыг сайтар
уухаарч, би олон түмнээс уучлал
хүсэж байна” гэж мэдэгдэв.
Ноён Моритомо Гакуэн бага
насны хүүхдэд эх оронч үзэл,
төлөвшүүлэх нэрээр үндсэрхэг
үзэл түгээхийг зорьдог, эрх
баригч намын томчуудтай холбоо
сүлбээтэй гэх мэт зөрчилтэй хүн
юм. Өнгөрсөн онд Моритомо 956
сая иенийн үнэлгээтэй газарт
134 саяыг төлсөн хэрэг илрэхэд
дуулиан дэгдэж эхэлсэн юм.
Хатагтай Абэ уг газар дээр барих
шинэ бага сургуулийн хүндэт
захирал болох байжээ. Гэвч
ноён Абэ газар зарахад биечлөн
оролцсон гэх нотолгоо гараагүй
учир дуулиан намдсан аж. Харин
засагдаагүй баримтаас үзэхэд
газар худалдахад оролцсон
түшмэлүүд Моритомогийн
улс төрийн ар талыг мэдэж
байжээ. Сангийн яамны нэгэн
тодруулгад, ноён Моритомо
хатагтай Абэ түүнтэй уулзаад
“Энэ сайн газар хөөцөлдөөд үз”
гэж хэлсэн мэтээр бичсэн аж.
Уг тодруулгад ноён Абэ зэрэг

Либерал Ардчилсан Нам дээд тушаалтнууд Моримотогийн сургуулийн ажилд холбоотой гэж дурдсан байна.

Ноён Абз газар худалдсантай холбоотой гэх шүүмжлэлийн нэвчлэсээр ирсэн. Харин шинжээчид үндэсний удирдагчид газар худалдах тушаал өгсөн гэх нотлох баримт байхгүй ч Сангийн яам баримтыг засварласан асуулгаас зайлсхийхэд хүнд гэж үзэж байна. Японы асуудлаарх мэргэжилтэн Тобиас Харрис "Сайд нь парламентад худал мэдээлэл өгч байхад ноён Абз хариуцлагаас мултарна гэдэгт итгэхэд бэрх" хэмээн тайлбарлав. Тэрбээр цааш нь Ерөнхий сайд яаран огцрох эрсдэл үүсээгүй ч ийн дуулиан "Абэгээ залхах" санаа бодол дэлгэрүүлж, ирэх намар дахиад сонгогдоход бэрхшээл учруулж болзошгүй гэсэн юм. Өнгөрсөн баасан гарганд дуулиантай холбоотой байж болзошгүй Сангийн яамны нэг ажилтан Кобед амиа хорлосныг цагдаагийн газар мэдээлсэн. Энэ хэрэг дуулиантай холбоотойг нарийн тогтоогоогүй ч газар худалдах ажлыг яамны дунд шатны түшмэл хариуцдаг аж.

Брайн Харрис

Статистикаас үзэхэд Өмнөд Солонгосод эдийн засгийн идэвхтэй 60-аас дээш насныхны тоо 20-иод насныхнаас өндөр байна. Энэ нь Зүүн Азийн энэ улсад хүн ам зүй ба эдийн засгийн хямрал нүүрлэхийн дохио болов. Өрнөд Европ хийгээд Японы Засгийн газрууд түүнчлэн хүн амын насжилт өндөрсөний улмаас ажиллах хүчний хомсдолтой тулгарч байгаа нь нийгмийн халамжийн үүргээ гүйцэтгэхэд нэлээд бэрхшээл үүсгэж буй. Гэвч хаана ч Өмнөд Солонгосоос илүү хүндрээсгүй байна. Тэнд өндөр настууд


харьцуулах аргагүй ядууралд
автсан учир тэтгэврийнхэн
амьдралаа залгуулахын тулд
үйлчлэгч хийдэг болжээ.
Өмнөд Солонгосын 65-аас
дээш насныхны бараг тал нь
ядууралд автжээ. Ханианы
их сургуулийн дэргэдэх
Нийгмийн хөгшрөлтийн

гурван хувь орчим байгаа. Гэвч их үйлдвэрлэж, экспортод гаргах загвар сүүлийн 70 жилийн хурдацтай хөгжилд гол үүрэг гүйцэтгэсэн ч хөрш Хятадын өрсөлдөөн, хиймэл оюун ухаан, автоматчиллын улмаас элэгдэж хуучирчээ. Өмнөд Солонгосын залуус цэцэг эхийнхээ хийж байсан цэнхэр захтны ажлыг хийх хүсэлгүй байдаг. Ням гарагт нийтлүүлсэн статистикийн мэдээнээс үзэхэд 2017 онд 20-иод насны дөрвөн сая залуу эдийн засгийн идэвхтэй гэжээ. Идэвхтэй гэдэг нэр томъёо ажил эрхэлж байгаа буюу хайж байгааг илэрхийлдэг.


Уг ангилалд багтаж байгаа 60-аад насныхны тоо 2016 оны 3.9 саяас нэмэгдэж 4.2 саяд хүрснийг энд дурдсан байна. Өнгөрсөн онд 60 ба түүнээс дээш насныхан бараг хагас саяар нэмэгджээ. Энэ тоо ахмадуудын ядуурал болон компанийн соёлыг илэрхийлж



66 ба түүнээс дээш насныхны ядуурал
(хүн амд эзлэх хувь)



Өмнөд Солонгосын хүн амд 65-аас дээш насныхны эзлэх хувь
(хувиар)



судалгааны хүрээлэнгийн тэргүүн Ли Сам Сик “Хэрэв хүн ам цөөрсөөр байвал Өмнөд Солонгост залуусын тоо буурч, хөгшчүүд харьцангуй нэмэгдэх болно. Ажиллагсдын тоо цөөрч, хэрэглээний түвшин доошилсноор одоогийн аж үйлдвэрийн бүтцийг авч явахад бэрхшээл тулгарна” гэжээ. Өндөр боловсролтой ажиллаа хүчиндээ ажил олгох гэж тэмцэж байгаа өнөө үед залуусын ажилгүйдэл 10 хувиас даваад байна. Энэ нь Өмнөд Солонгосын эдийн засагт асуулт үүсгэв. Эдийн засгийн жилийн өсөлт нь

байгаа юм. Өмнөд Солонгосын томоохон корпорациуд тус улс хүн амын насжилтаар дэлхийд дээгүүрт орджийг үл харгалзан ажилчдаа эрт тэтгэвэрт гаргахыг яардаг. Ийм тохиолдолд улсын тэтгэвэр өчүүхэн бага тул настай хүмүүс өөр ажил, гол төлөв мэргэжлийн бус ажил хайхад хүрдэг аж. Өмнөд Солонгосын Ерөнхийлөгч Мин Жэ Ин сар бүрийн 200,000 воны тэтгэмжийг 2021 он гэхэд 300,000 хүртэл нэмэгдүүлж, энэ асуудлыг хөнгөвчлөхөө амласан байна.



Робин Хардинг

Японы Сангийн яам Ерөнхий сайд Шинзо Абэ болон түүний эхнэрийн нэрийг хасч, хуурамч баримт үйлдсэнээ хүлээн зөвшөөрлөө. Үүний дараа улсын мэдлийн газрыг хямд үнээр зарсан дуулиан дэгдэж, Засгийн газрыг ганхуулж эхэллээ. Сангийн яамны мэдээнд Осака хот дахь газрыг хэт үндсэрхэг үзэлтэн Моритомо Гакуэны сургуульд худалдсан тухай баримтууд парламентад танилцуулахад 14 засвар хийснээ хүлээжээ. Уг мэдээ Сангийн сайд Таро Асогийн суудлыг ганхуулж, ноён Абэ энэ намар болох сонгуулиар Либерал ардчилсан намын тэргүүнээр гурав дахь удаагаа үлдэх эсэхэд эргэлзээ үүсгэв. Өнгөрсөн оны

Эдийн засаг

Дэлхий нийтийг хамарсан таатай жилийг бүрэн ашиглах хэрэгтэй

◀1

Тус улс 2018-2020 онд энэ өсөлтөө хадгалах төсөөллийг Дэлхийн банкнаас гаргасан. Ийнхүү дэлхийн болон хөрш орнуудын эдийн засаг тогтвортой байх нь манай улсын эдийн засагт таатай нөлөөлөхөөр байгаа юм.

Монгол Улсын төсөв эрдэс баялгийн гадаад зах зээлээс ихээхэн хамаардаг онцлогтой. Үүнд нөлөөлдөг алт, зэс, нүүрс зэрэг түүхий эдийн үнэ энэ онд тогтвортой байна гэх таамгийг эдийн засагчид хэлж байна. МУИС-ийн Эдийн засгийн тэнхимийн багш Л.Нарантуяа “2018 онд манай улсын эдийн засаг таван хувийн өсөлттэй байх төлөвтэй. Голлох экспортын бүтээгдэхүүний үнэ өссөн энэ таатай үеийг маш сайн ашиглах хэрэгтэй. Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт энэ онд тэлнэ. Мөн уул уурхайн бус экспортын өсөлт эрдэс баялгийн салбарыг гүйцэхгүй ч бага дүнгээр тэлэх төлөвтэй байна. Гэхдээ аль аль салбарт нь огцом өсөлт гарах хүлээлт хараахан байхгүй” гэлээ.

Харин энэ онд гадаадын шууд хөрөнгө оруулалт тэлэхгүй нь. Засгийн газрын тогтворгүй бодлого, бизнесийн орчин зэрэг нь гаднын хөрөнгө оруулагчдыг татахад саад учруулж буй. Тиймээс өөрсдийн дотоод нөөц, боломжоо ашиглаж, үндэсний үйлдвэрлэгчдээ дэмжсэн бодлого шаардлагатай байна. Түүнчлэн дэлхийн эдийн засаг тогтвортой байгаа энэ үеийг ашиглаж эдийн засгаа төрөлжүүлэх, санхүүгийн бус хөшүүргүүдийг хэрэглэж



С.Батсайхан / ЗГМ©

Эдийн засагт тогтвортой байдал ноёлно

ХАНШИЙН ЭРСДЭЛ БАЙХГҮЙ



Б.Түвшинтөгс
Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ ЗУРГААН ХУВЬД ХҮРНЭ



Б.Лхагважав
МУХАУТ-ын Ерөнхийлөгч

БИЗНЕС ЭРХЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН БОДЛОГО ХЭРЭГТЭЙ



С.Дэмбэрэл
Эдийн засагч

-Улсын эдийн засаг төсвийн болон мөнгөний бодлогоос ихээхэн хамаардаг. Засгийн газар зардлаа өсгөх боломжгүй болсон, өрийн тааз тулсан зэргээс шалтгаалж сангийн бодлогын эдийн засаг дахь нөлөө хумигдмал байгаа. Харин мөнгөний бодлогоор дамжуулж эдийн засагт нөлөөлөх илүү боломжтой. Энэ онд гадаад валютын урсгал нэлээд өсөх хандлагатай байгаа учир төгрөгийн ханшид дарамт учрах эрсдэл харагдахгүй байна.

-2017 оны 5.1 хувийн өсөлт бол НӨАТ-ын бүртгэлийн системийн үр дүн. Түүнээс биш бүтээмж дээшилсэн зүйл огт байхгүй. МУХАУТ-аас 2018 онд манай улсын эдийн засгийн өсөлт зургаан хувьд хүрнэ гэж төсөөлж байгаа. ОУВС-гийн явуулж буй бодлого, санхүүжилтийн үр дүнд төсвийн алдагдал буурах байх. ОУВС-гаас авах 5.5 тэрбум ам.долларыг Монголбанк болон төсвийн алдагдлыг бууруулахад зарцуулна. Тиймээс Монгол Улсын эдийн засгийн өсөлт унахгүй, тогтвортой байх баталгаа нь ОУВС гэж хэлж болно.

-Эдийн засаг сайжрах эсэхийг өрхийн бодит орлого, бизнесийн цэвэр ашгаас харах хэрэгтэй. Бизнес эрхлэгч болон иргэдэд чиглэсэн бодлого шаардлагатай байна. Энэ онд татварын багц хуульд бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалсан өөрчлөлт оруулах санал гаргаж байгаа нь сайн мэдээ. Гэхдээ ийм зэрэг төлөв, тогтвортой байдал удаан үргэлжлэхгүй. 2021 оноос манай улс бондын зээлүүдээ төлж эхэлнэ. Мөн дэлхийн зах зээлд ч савлагаа гарах магадлалтай байгаа. Тиймээс 2018 он бол эдийн засгийн хувьд тун чухал жил болох учиртай. [ЗГМ]

СТАТИСТИК

Төсөв, мөнгөний бодлогын үндсэн үзүүлэлт эерэг гарлаа

Хугацаа хэтэрсэн зээл буурч, төл-бөрийн тэнцэл ашигтай гарав

Б.Мөнх
ЗГМ

Үндэсний статистикийн хорооноос энэ оны хоёрдугаар сарын нийгэм, эдийн засгийн байдлын ээлжит тайланг танилцууллаа. Өнгөрсөн сард гарсан онцлох өөрчлөлтийг тоймлон хүргэж байна. Нийгэм, эдийн засгийн тусгал нь статистикийн тоон

үзүүлэлт байдаг. Энэ жишгээр авч үзвэл, макро эдийн засагт эерэг үзүүлэлт зонхилж байна.

ИНФЛЯЦ НАМ ТҮВШИНД ТОГТВОРТОЙ БАЙНА

Монголчуудын уламжлалт баяр сар шинийн баяр тохиосон хоёрдугаар сард инфляц ялимгүй өсчээ. Инфляциар тодорхойлогдох хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс 6.9 хувиар өссөн байна. Харин нэгдүгээр сартай харьцуулахад 0.8 хувийн өсөлт ажиглагджээ. Уг өсөлтөд хүнсний бараа, бүтээгдэхүүний үнэ түлхүү нөлөөлсөн байна. Монголбанкны мөнгөний бодлогод энэ оны турш инфляцын түвшинг найман хувиар

зурагласан. Одоогийн байдлаар инфляц төв банкны зорилтот түвшнээс 1.1 хувиар нам байна.

МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ 29 ХУВИАР НЭМЭГДЖЭЭ

Энэ оны хоёрдугаар сард мөнгөний нийлүүлэлт 15.9 их наяд төгрөг болж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 3.6 их наядаар өсчээ. Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө өнгөрсөн сарын эцэст 850.4 тэрбум төгрөг болж, өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад 10 хувиар буурсан байна. Банк, санхүүгийн салбарын эрүүл мэндийг илтгэх хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл хоёрдугаар сард 993

тэрбум төгрөг болж, жилийн өмнөх үетэй харьцуулахад 5.5 хувиар буурчээ. Тэрчлэн хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 7.2 хувийг эзэлж байна. Тайлант хугацаанд банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 1.3 их наяд төгрөг болж, нэгдүгээр сараас хойш 6.1 хувиар өсчээ. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 9.2 хувийг эзэлж байна.

ТӨСВИЙН НИЙТ ТЭНЦЭЛ АШИГТАЙ ГАРЛАА

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 73.1 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа. Татварын нийт орлого

1.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 29.1 хувиар өссөн байна. Татварын бус орлого 12 тэрбумаар буурсан ч Онцгой албан татварын орлого 41.2 тэрбум төгрөг болж, нэмэгджээ. Мөн Орлогын албан татвар болон Нэмэгдсэн өртгийн албан татвар, Нийгмийн даатгалын орлого тус тус өссөн нь дээрх өсөлтөд голлон нөлөөлжээ. Төсвийн орлого, зарлага өнгөрсөн сард зэрэг өссөн байна. Төлбөрийн тэнцэл өнгөрсөн оны дөрөвдүгээр улиралд 1.3 тэрбум ам.долларын ашигтай гарлаа. Энэ нь 2016 оны мөн үетэй харьцуулахад ашгийн хэмжээ нэг тэрбум ам.доллараар нэмэгдсэн үзүүлэлт.

ГАДААД ХУДАЛДААНЫ АШИГ ХОЁР ДАХИН БУУРАВ

Өнгөрсөн сард манай улс дэлхийн 109 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 1.6 тэрбум ам.долларт хүрчээ. Үүний 726 сая ам.доллар нь импорт бол үлдсэн экспорт байна. Гадаад худалдааны тэнцэл 2017 оны эхний хоёрдугаар сард 334.2 сая ам.долларын ашигтай гарч байсан. Тэгвэл энэ оны эхний хоёрдугаар сард л 112.4 сая ам.долларын ашигтай гарлаа. Экспорт өсөхөд хагас боловсруулсан алтны экспорт 41.4 сая ам.доллараар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Импорт өмнөх оны мөн үеэс өсөхөд дизелийн түлш болон машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, түүний эд анги өссөн нь голлон нөлөөлжээ. [ЗГМ]

ЗГМ ТОВЧХОН

» **ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ**

36.3

Мянга. Улсын хэмжээнд ажил хайж бүртгүүлсэн иргэд энэ оны хоёрдугаар сарын байдлаар 36.3 мянга болов. Үүний 11.7 мянга буюу 32.3 хувь нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна.

» **ТӨСӨВ**

33.4

Тэрбум төгрөг. Нийгмийн даатгалын сангийн орлого өнгөрсөн сард өмнөх оны мөн үеэс 33.4 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

» **ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ**

Монголын хөрөнгийн бирж давхар бүртгүүлэх анхны компанийн хүсэлтийг хүлээн авлаа. Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй уул уурхайн компанийн уг хүсэлтийг ажлын 15 хоногт хянан шийдвэрлэх юм байна.

» **АРИЛЖАА**

2.5

Их наяд төгрөг. Монголын хөрөнгийн бирж мягмар гарагийн үнэт цаасны арилжаагаар 27 хувьцаат компанийн 85,185 ширхэг хувьцаа арилжлаа. Энэ өдөр 11 компанийн хувьцааны ханш өсөж, 14 компанийнх буурсан бол хоёр компанийн хувьцааны ханш тогтвортой байв. Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ энэ өдөр 2.5 их наяд төгрөгтэй тэнцлээ.

» **БОНД**

147.3

Сая төгрөг. Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 1500 ширхэг үнэт цаасыг 147.3 сая төгрөгөөр арилжлаа.

» **АЖ ҮЙЛДВЭР**

14.2

Хувь. Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл хоёр их наяд төгрөгт хүрч, 14.2 хувиар өсчээ.

» **ДЭД БҮТЭЦ**

48.1

Тэрбум төгрөг. Агаарын тээврийн салбарын орлого энэ оны хоёрдугаар сард 48.1 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 10.5 хувиар нэмэгджээ.

» **НОГДОЛ АШИГ**

56.64

Төгрөг. “Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ” компани нэгж хувьцаандаа 56.64 төгрөгийн ногдол ашиг хуваарилна.

ВАЛЮТЫН ХАНШ

АНУ доллар	2,396.22
Евро	2,951.90
Японы иен	22.40
ОХУ-ын рубль	42.06
БНХАУ-ын юань	378.43
БНСУ-ын вон	2.25

ЗГМ: ИНФОГРАФИК



Эдийн засаг

Инновацигүйгээр ирээдүйн тухай яриад ч хэрэггүй

Нүүрс ачсан 1500 автомашины цуваа 3500 гаруй ширхэг iPhone X-ийн мөнгөн дүнтэй тэнцэнэ

Г.Байгал
@baigalZGM

Нэг ширхэг iPhone X, 34 тонн нүүрстэй тэнцэж байна. Монголчууд iPhone цувралын шинэ загварыг авахын тулд 30 гаруй тонн коксжих нүүрстэй тэнцэх хэмжээний мөнгө зарцуулж буй. Сонирхолтой нь, зарим албан ёсны борлуулагчийн мэдээлж буйгаар худалдаанд гараад нэг их удаагүй уг загварын эрэлт Монголд нийлүүлэлтээ давж, хүлээлт үүсгээд буй аж. Олон улсын зах зээлд 256 гигабайтын багтаамжтай iPhone X дөрвөн сая төгрөг хүртэлх үнэтэй байхад манай улсын төрийн өмчит “Эрдэнс Тавантолгой” компани тонн нүүрсээ 59 ам.доллар буюу 141 мянган төгрөгөөр борлуулж буйг тус компанийн гүйцэтгэх захирал Д.Ариунболд өнгөрсөн долоо хоногт мэдээлсэн юм. Одоогоос хэдэн сарын өмнө Монголын экспортын гол хаалга Гашуунсухайт, Ганцмодны боомтод 70-100 тоннын даацтай 1500 автомашины гацаа үүссэнийг бид мэднэ. Тэгвэл олон километр сунайн үргэлжилсэн урт цуваа ердөө 3500 гаруй ширхэг iPhone X-тэй тэнцэхүйц байжээ.

Дэлхийн инновацийн индексээр Монгол Улс 143 орноос 52 дугаарт оржээ

Гаалийн ерөнхий газрын мэдээлэлд дурдсанаар өнгөрсөн онд Монгол Улс эзсийн 1.4 сая тонн баяжмалыг 1.6 тэрбум ам.доллараар борлуулсан байна. Уг түүхий эдийн экспортын хэмжээг, борлуулалтын орлогод нь хуваан үзвэл нэг тонн баяжмал дунджаар 1140 ам.долларт хүрсэн байх юм. Монголын эзсийн зах зээлийн гол тоглогчдын нэг “Оюутолгой” компани “Монголд үйлдвэрлэв” гэсэн шошготой шуудайд савласан эзсийн баяжмалаа хоёр тонноор савлан, хилийн чанадад экспортолдог.Тэгвэл



С.Батсайхан / ЗГМ©

бид “Оюутолгой”-н шуудайлсан баяжмалыг 4-5-ыг борлуулсан дүнгээр монголчуудын хамгийн өргөн хэрэглэдэг Toyota Prius 30 автомашиныг авдаг байх жишээтэй.

Түүнчлэн Монгол Улс 2017 онд нэг сая гаруй тонн түүхий нефть борлуулж, 374 сая ам.доллар олсон. Гэсэн атлаа үүнээс хоёр дахин өндөр үнээр газрын тосны эцсийн бүтээгдэхүүн худалдан авсан байна. Бас газрын дээр, доороо эрчим хүчний түүхий эдийн арвин баялагтай Монгол Улс жилд 130-140 сая ам.доллараар цахилгаан эрчим хүч, 93 сая ам.доллараар химийн бүтээгдэхүүн импортлосоор байна. Хэрвээ бид олон жил ярьсан газрын тос боловсруулах, химийн аж үйлдвэрлэлээ хөгжүүлж, эрчим хүчний станц байгуулж, дэвшилтэт технологи нутагшуулсан бол энэ их мөнгийг гадагш урсгахгүй, дотооддоо нэмүү өртөг шингээж, ажлын байр олноор бий болгох байлаа.

Одоогоор олон улсын зах зээлд Louis Vuitton-ийн арьсан цүнх дунджаар 2500 ам.долларын үнэтэй байгаа. Малын гаралтай түүхий эдээр баялаг Монгол Улс малын арьсаар ийм чанарын цүнх хийж, нэмүү өртөг шингээгээд зарахад л 50 тонн төмрийн хүдрийн баяжмалын экспорттой дүйх хэмжээний орлого олохоор байна. Энэ мэт нөөц боломжоо инноваци, нэмүү өртөгтэй хослуулж чадвал 20 гаруйхан их наяд төгрөгөөр хэмжигддэг, манай цомхон эдийн засгийг сэвхийтэл босгоод ирж болохоор билээ. Наанадаж л монгол

ЗГМ: ИНФОГРАФИК



төгрөгийн эсрэг галзуураад буй гадаад валютуудын ханш хүртэл ингэтлээ цойлж чангархгүй байлаа.

Энэ бол түүхий нүүрс инноваци шингэхгүйгээр мөнгө босгохгүй гэдгийг ойлгуулж рүү шилжиж байна” хэмээн Дэлхийн өрсөлдөх чадварын

гэсэн үйлдвэрлэлийн ид шид, экспорт, импортын хэдхэн бүтээгдэхүүнээс харагдаж байна.

“Өрсөлдөх чадвар өнөөдөр биетээс биет бус руу, тонноор хэмжигдэх бараа таваараас байгаар хэмжигдэх мэдээлэл рүү шилжиж байна” хэмээн Дэлхийн өрсөлдөх чадварын

төвийн захирал, профессор Стефан Гарелли өгүүлжээ. Өөрөөр хэлбэл, мэдлэгийг баялаг болгож, инновацийг бүтээж буй улс орнууд л хөгжиж байгаа юм. Товчхондоо, улс орнуудын хөгжил дэвшлийг байгалийн баялаг биш, инноваци, технологийн

гайхамшиг тодорхойлсоор ирлээ. Гэтэл бид баялгаа асар хямд зарчихаад, оронд нь өндөр үнээр инноваци шингэсэн бүтээгдэхүүн авч сууна.

Биднийг талцаж, хагарч илүү их алт ухаж, илүү их нүүрс экспортлохоор улайрч байх зуур бусад улс мэдлэгийг баялаг болгохын төлөө хичээж байна. Copen-ийн их сургууль, Дэлхийн оюуны өмчийн байгууллагын хамтран гаргадаг “Дэлхийн инновацийн индекс 2017” тайлангаас үзэхэд Монгол Улс 143 орноос 52 дугаарт оржээ. Энэ жагсаалтыг Швейцар тэргүүлж, Швед удаалсан. Скандинавын Швейцар, Швед болон Израйль зэрэг орон жижиг хэрнээ шинжлэх ухаан, технологийн салбартаа бусад улстай харьцуулахад хавьгүй их хөрөнгө зарцуулж, хэдхэн төрлийн өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүнийг эдийн засгийн тулгуураа болгож байна.

Бид заавал ухаалаг утас үйлдвэрлэж, Apple шиг компанитай болох албагүй. Гэсэн ч гагцхүү бэлэн нөөц боломжоо ашиглаад, наад зах нь эхний шатны боловсруулалт хийгээд зарахад л өдгөө 50 ам.доллартай тэнцэж буй нүүрсний үнээ 2-3 дахин өсгөөд зарчих боломж байсаар.

Цаашлаад элдэв эм тариа хэрэглэдэггүй, “органик мах” нэртэй брэнд үүсгэж болж байна. Үүнийгээ эрүүл ахуйн стандарт хангасан гэдгийг баталж чадвал Бээжингийн баячуудын хэрэгцээг монгол брэндийн мах хангаж, килограммыг нь 20-30 ам.доллараар экспортолх бололцоо бий.

Ноолуур ч мөн ялгаагүй. Тооны ихээс биш чанар, өндөр зэрэглэлийг бодолцвол монгол ноолууран бүтээгдэхүүн тансаг зэрэглэлийн бараанууд шиг цөөн тоогоор ч гэлээ өндөр үнээр зарагдаад байж чадна. Наанадаж л нүүрсний нөөцөөрөө дэлхийд толгой цохидог Монголын нүүрснээс 5000 гаруй төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологи бий. Тэдгээрээс зөвхөн түлш, шатахуун, эрчим хүч, химийн бүтээгдэхүүнээ гаргаж авахад л Монгол Улс асар их мөнгө хэмнэх боломж бүрдэх юм.

Гэтэл сүүлийн жилүүдэд уул уурхайн бүүм боллоо гэсэн хэрнээ тэдгээр ашигт малтмалаа бүрэн боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж огт сурсангүй. Бид нүүрсээ ухаж, хамгийн ойрын зах зээлд хямд өртгөөр гаргаж, богино хугацаанд ашиг олох тухай л боддог. Бас болоогүй түүнийгээ тогтвортой ч борлуулчихгүй, гацааж, хүлж дөнгөнө. [ЗГМ]

ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ:

